



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАР

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ГҮЙЦЭТГЭГЧ:

“Эрдэмтэй мэдлэг холбоо”
нийгэмд үйлчлэх ТББ

Судалгааны багийн гишүүд:

Багийн ахлагч:	М.Хандармаа
Ахлах судлаач:	Э.Батбаяр
Судлаачид:	М.Уранчимэг Э.Тэгшбуян Ө.Бат-Эрдэнэ

Улаанбаатар
2024

АГУУЛГЫН ТОВЬЁОГ

АГУУЛГЫН ТОВЬЁОГ	I
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	III
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	IV
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	V
НЭГ. УДИРТГАЛ	1
1.1. Судалгааны асуудал	1
1.2. Судалгааны зорилго, зорилт	2
1.3. Судалгааны хамрах хүрээ	3
1.4. Судалгааны ач холбогдол	3
ХОЁР. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ	4
2.1. Хил хамгаалах байгууллагын үүсэл, хөгжил	4
2.2. Хил хамгаалах байгууллагын эрх зүйн орчин, үндсэн чиг үүрэг	5
ГУРАВ. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН, МЭДЭЭ	6
3.1. Хилийн зурвас, бүсэд түр нэвтрэх зөвшөөрөл олгосон талаарх тайлан, мэдээ ...	6
3.2. Хил хамгаалах ерөнхий газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал	6
3.3. Хилийн цэргийн тусгай архивын хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлсэн байдал	7
3.4. Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн сан”-аас лавлагаа, мэдээлэл олгосон байдал	9
3.5. Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах 2024 оны ажлын жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	9
3.6. Хилчдийн нийгмийн хамгаалал 2024 хөтөлбөр”-т оруулах нэмэлт өөрчлөлт оруулсан төлөвлөгөөний хэрэгжилт	14
ДӨРӨВ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	18
3.1. Судалгааны эх олонлог, түүврийн хэмжээ	18
3.2. Судалгааны өгөгдлийн шинжилгээний арга	18
ТАВ. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН	21
5.1. Судалгаанд оролцогчдын байршил, хүн ам зүйн шинж байдал	21
5.2. Хил хамгаалах байгууллагын мэдээллийн ил тод байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	23
5.3. Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний шуурхай байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	29

5.4 Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ.....	31
5.5 Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний чанарт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	32
5.6 Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ёс зүй, мэдлэг ур чадварт өгсөн иргэдийн үнэлгээ.....	33
5.7 Үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдалд хэрэглэгчийн үнэлгээ	35
5.7 Ярилцлагын судалгааны үр дүн	37
ЗУРГАА. ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	39
6.1. Судалгааны дүгнэлт	39
6.2 Зөвлөмж.....	42

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БОНХАЖЯ	Байгал орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОНХЯ	Байгал орчин, ногоон хөгжлийн яам
БОАЖГ	Байгал орчин, аялал жуулчлалын газар
МУ	Монгол улс
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОБХ	Онцгой байдлын хэлтэс
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХБ	Хил хамгаалах байгууллага
ХЦАХ	Хугацаат цэргийн алба хаагч
ХЦДБЧ	Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга
ХШН	Хилийн шалган нэвтрүүлэх
НҮТББ	Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллага

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын байршил.....	21
Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн шинж байдал.....	21
Хүснэгт 3. ХХБ-ын мэдээллийн ил тод нээлтэй байдалд өгсөн иргэдийн үнэлгээ.....	29
Хүснэгт 4. ХХБ-ын үйлчилгээний шат дамжлага, шуурхай байдалд өгсөн иргэдийн үнэлгээ	30
Хүснэгт 5. ХХБ-ын үйлчилгээний хүртээмжтэй байдалд өгсөн иргэдийн үнэлгээ	32
Хүснэгт 6. Хил хамгаалан байгууллагын үйлчилгээний чанарт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	33
Хүснэгт 7 Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын ёс зүйн байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	34
Хүснэгт 8. Хил хамгаалах байгууллага үйлчилгээндээ хүний эрхийг хүндэтгэсэн байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	36
Хүснэгт 9. Хил хамгаалах байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн үнэлгээний нэгдсэн дүн	40

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны шалгуур үзүүлэлт, хэмжих нэг	19
Зураг 2. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал /хувиар/	22
Зураг 3. Судалгаанд оролцогчдын ХХБ-с үйлчилгээ авсан давтамж /хувиар/	22
Зураг 4. Хил хамгаалах байгууллагаас үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлага.....	23
Зураг 5. Хил хамгаалах байгууллагын талаарх мэдээлэл хүлээн авдаг суваг /тоогоор/..	25
Зураг 6. Хил хамгаалах байгууллагын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ /тоогоор/.....	26
Зураг 7. ХХЕГ ба хилийн боомтын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нээлттэй ил тод байдалд өгсөн иргэдийн үнэлгээ	26
Зураг 8. ХХЕГ-ын цахим хуудсанд зочилсон байдал	27
Зураг 9. ХХБ-ын цахим хуудснаас хэрэгтэй мэдээллээ олж авсан байдал	28
Зураг 10. ХХБ-ын лавлах утсанд холбогдсон байдал	28
Зураг 11. ХХБ-с үйлчилгээ авахад хэрэглэгчийн зарцуулдаг хугацаа /тоогоор/	30
Зураг 12. Үйлчилгээний хүнд сурталгүй, шуурхай байдал иргэдийн өгсөн үнэлгээ.....	31
Зураг 13. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын ёс зүйд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ	34
Зураг 14. Хил хамгаалан байгууллагын үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ /дэлгэрэнгүй/	35

НЭГ. УДИРТГАЛ

1.1. Судалгааны асуудал

Монгол Улсын Их Хурлаас хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2020 онд шинэчлэн баталж мөрдүүлсэнтэй холбоотойгоор Засгийн газраас хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах явц, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэхтэй холбогдсон харилцааг зохицуулан журамласан. Журамд төрийн захиргааны байгууллагууд жил бүр үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр тусгасан нь дэлхийн улс орнуудын Засгийн газрын нэгэн адил сайн засаглал, хариуцлага, ил тод байдал, хөгжлийн илүү үр дүнд хүрэх, бодит үр дүнг бий болгох талаар оролцогч талуудаас тавьж буй шахалт шаардлагад мэдрэмжтэй хандах болсны тод илрэл юм.

Цаашлаад Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тушаалаар баталсан “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийг удирдлага болгон Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн хөндлөнгийн үнэлгээг хийж ажиллав.

Хууль зүйн сайдын эрхлэх хүрээний байгууллагын нэг болох Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Хил хамгаалах ерөнхий газар нь хэрэглэгчийн үнэлгээг 12 дахь жилдээ хийлгэж байгаа бөгөөд энэ удаа “Эрдэмтэй мэдлэг холбоо” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын судалгааны баг гэрээний дагуу 2024 оны 10-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ. Тус байгууллагаас хэрэглэгчийн үнэлгээг агентлаг, байгууллагын бодлогын хэрэгжилтийн үр нөлөө, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар тухайн байгууллагын алба хаагч, үйлчлүүлэгч насанд хүрсэн иргэдийн 3-5 хүртэлх хувийг, эсхүл тухайн байгууллагаар үйлчлүүлэгч аж ахуйн нэгжийг хамруулан явуулсан санал асуулгын дүнг үндэслэн гаргахыг зорьсон болно.

Хил хамгаалах байгууллагаас иргэд, ААНБ-д үзүүлж байгаа үйлчилгээг хилийн боомтуудад журам мөрдүүлэх, хилийн боомтуудын цагийн хуваарийг мэдээлэх, хилийн бүс зурваст нэвтрэх зөвшөөрөл олгох, архивын лавлагаа гаргах, Улсын хилийн музейн үзмэрээр үйлчлэх, ХХБ-ыг сурталчилж, урлаг соёлоор үйлчлэх, өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх гэсэн хүрээнд судалгааг явууллаа.

Дээр дурдсан үйлчилгээний чанар, хүртээмж, үйлчилгээг авах нөхцөл боломж, үйлчилгээний орчны талаарх сэтгэл ханамж, санаа бодлыг тухайн үйлчилгээг авагч болон үйлчилгээг үзүүлэгч алба хаагчдын төлөөллийг хамруулан санал асуулга, ярилцлагын аргаар тандан судалж, Хилийн болон боомтын тухай хууль, хилийн боомтын мөрдөх журам, хилийн боомтын асуудлаар байгуулсан Монгол улсын олон улсын гэрээ хэлэлцээр, бусад дүрэм журам, зааварт нийцсэн байдлыг тэдгээрийн биелэлтийн тайлан, мэдээ болон бусад холбогдох бичиг баримтад судалгаа, дүгнэлт хийж, цаашид анхаарах асуудлаар зөвлөмж өгөхөд чиглүүлэн ажиллалаа. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамаарч, зарим тайлан мэдээ, мэдээлэл нь нууцын зэрэглэлтэй байх тул тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор баримт бичгийн судалгааг тодорхой боломжит хүрээнд хийж гүйцэтгэсэн болно.

1.2. Судалгааны зорилго, зорилт

Хил хамгаалах байгууллагын төрийн үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэд, аж ахуйн нэгжийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход хэрэглэгчийн үнэлгээний судалгааны зорилго оршино. Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- Хил хамгаалах байгууллагын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдал, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх;
- Цаашид дээрх үйлчилгээний чиглэлээр байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах;
- Иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн үзүүлэх үйлчилгээг сайжруулах, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;
- Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд цаашид анхаарах асуудал, сайжруулах арга замыг тодорхойлсон дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

1.3. Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход голчлон анхаарсан. Судалгааны зорилтот бүлэгт Хил хамгаалах байгууллагаар үйлчлүүлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамруулан судалгааны өгөгдлийг цуглуулсан. Харин судалгаанд Хил хамгаалах Ерөнхий газар, Чингис хаан” ОУ-ын нисэх буудал, “Замын -Үүд” авто болон төмөр замын боомт зэрэг газруудыг хамруулсан.

1.4. Судалгааны ач холбогдол

Хэрэглэгчээр байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлын ач холбогдол нь Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, цаашид анхаарах асуудал, үйлчилгээг сайжруулах арга замыг тодорхойлон дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэгт оршиж байна.

ХОЁР. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ

2.1. Хил хамгаалах байгууллагын үүсэл, хөгжил

“Монгол Улсын хил халдашгүй дархан байна” хэмээх үгийг эрхэм зорилгоо болгосон Хил хамгаалах ерөнхий газар үүсэл, хөгжил нь Монгол улсын гадаад, дотоод байдал 1930-аад оны эхээр хурцадсаны улмаас төр, засгаас улс орноо батлан хамгаалахын тулд 1933 онд Хилийн харуулын цагдааг татан буулгаж, улсын хилийг мэргэжлийн цэргийн хүчээр хамгаалах болж хилийн отряд, комендатуруудыг байгуулснаар уг байгууллагын үндэс суурь тавигдсан гэж үздэг. 1933 оны 1-р сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Дотоодыг хамгаалах газарт баруун ба өмнөт хязгаарыг хамгаалах үүрэг өгч, анхны хилийн отряд, комендатуруудыг байгуулснаар орчин үеийн Хил хамгаалах байгууллага үүссэн гэж үздэг юм. 1990 онд НАХЯ татан буугдаж, УАБХЕГ байгуулагдан түүний харъяанд Хилийн цэрэг үйл ажиллагаагаа явуулав. 1993 онд “Хилийн тухай хууль” батлагдаж, Хилийн цэргийг удирдах газар байгуулагдсан юм. ХЦУГ нь 1996 он хүртэл Засгийн газрын дэд бүтцийн байгууллага болжээ.

Хил хамгаалах байгууллага нь 1996 оноос БХЯ-ны харъяа Засгийн газрын тохируулагч агентлаг, 2000 оноос Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжиж Засгийн газрын тохируулагч агентлаг-Хилийн цэргийг удирдах газар нэртэйгээр тус тус ажиллаж ирсэн бөгөөд 2002 оноос Засгийн газрын тохируулагч Агентлаг-Хил хамгаалах ерөнхий газар нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын Хилийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн холбогдох заалтын¹ дагуу улсын хилийн талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хилийн шугамыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх, хил орчмын дэглэмийг сахиулан, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хилийн зөрчлийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах, улсын хилийн зурвас, хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох арга хэмжээ

¹ www.legalinfo.mn Монгол Улсын Хилийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйл, Улсын Их Хурлаас 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталсан.

авах, хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн талаархи мэдээллийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дамжуулах зэрэг чиг үүргийг Хил хамгаалах байгууллага хариуцан гүйцэтгэж байна.

2.2 Хил хамгаалах байгууллагын эрх зүйн орчин, үндсэн чиг үүрэг

Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Олон Улсын гэрээ, хэлэлцээрүүд, Монгол Улсын хилийн тухай хууль, Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм, Монгол Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам, Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр, Хил хамгаалах байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрийн дагуу улсын хил хамгаалалтыг зохион байгуулж байна. Хил хамгаалах байгууллага нь дараах үндсэн чиг үүрэгтэй. Үүнд:

- Улсын хилийн талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- Улс орны хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах;
- Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, улсын хилийн дэглэмийг сахиулах;
- Улсын хилийн шугамыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байх;
- Хил орчмын дэглэмийг сахиулан, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, хилийн зөрчлийн асуудлыг хуульд заасны дагуу шийдвэрлэх;
- Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулах;
- Улсын хилийн зурвас, хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох арга хэмжээ авах;
- Хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох;
- Агаарын хилийг зөрчсөн байж болзошгүй нисгэгчтэй болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн талаарх мэдээллийг зэвсэгт хүчний агаарын цэргийн анги, салбарт шуурхай дамжуулах зэрэг болон хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг.

ГУРАВ. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН, МЭДЭЭ

3.1 Хилийн зурвас, бүсэд түр нэвтрэх зөвшөөрөл олгосон талаарх тайлан, мэдээ

Улсын хилийн зурвас, бүсэд түр нэвтрэх зөвшөөрлийг Монгол Улсын хилийн тухай хуулийн 25, 26, 30, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2-ын 10.4, 10.5 дугаар зүйлийг үндэслэн зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуйн, нэгж байгууллагад 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар давхардсан тоогоор 2936 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, 87569 хүн, 54005 тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгон хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавьж ажилласан. Үүнээс улсын хилийн зурваст 2217, бүсэд 719 зөвшөөрөл олгосон. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн зурвас, бүсэд түр нэвтэрсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 19.4 хувиар, хүний тоо 22.9 хувиар, тээврийн хэрэгслийн тоо 25.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 306 хувь хүн, аж ахуйн нэгж аялал жуулчлал, 1532 аж ахуй нэгж нүүрс тээвэр, 1098 аж ахуй нэгж судалгаа шинжилгээ хийх, бүтээн байгуулалт, авто болон төмөр зам тавих, ашигт малтмал хайгуул, олборлолт, тээвэрлэлт, гаалийн хяналтын бүс ажиллуулах зорилгоор улсын хилийн зурвас, бүсэд түр нэвтэрсэн байна.

3.2 Хил хамгаалах ерөнхий газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал

Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2016 оны А/167, 2019 оны А/38 дугаар тушаалыг удирдлага болгон Хил хамгаалах байгууллагын удирдлагад хандаж иргэд, алба хаагчдаас гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бичгээр болон нээлттэй утас /51260994/, Засгийн газрын “11-11” төвөөр дамжуулан хүлээн авч, өргөдөл гомдол, санал хүсэлтийг “BMS” программд бүртгэж, шийдвэрлэлтийг тусган ажиллаж байна.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нийт 7653 өргөдөл, гомдол ирснээс 7467 өргөдөл, гомдлыг байгууллагын эрх хэмжээнд шийдвэрлэн зохих хариуг өгч, 186 өргөдөл, гомдлыг судалж байна. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол Засгийн газрын “11-11” төвд 87 өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 97,5 хувьтай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын гишүүд, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлүүлэхээр уламжлан ирүүлсэн 7 өргөдлийн хариуг

өгч, 1 өргөдөл судлагдаж байна. Өргөдөл, гомдол хянан хэлэлцэж дүгнэлт гаргах комиссын 10 удаагийн хуралдааныг зохион байгуулж, 16 ахмад хилчин, 27 алба хаагч, 2 алба хаагчийн ар гэрээс ирсэн өргөдлийг хэлэлцэн, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, хариуг хуулийн хугацаанд өгсөн. Хил хамгаалах ерөнхий газрын хэмжээнд ирсэн Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээний тайланг сар бүрийн 05-ны дотор гаргаж, байгууллагын цахим хуудаст байршуулсан. Хил хамгаалах байгууллагын 2024 оны өргөдөл, гомдлын I, II, III улирлын тайлан мэдээг нэгтгэж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

3.3 Хилийн цэргийн тусгай архивын хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлсэн байдал

Хилийн цэргийн тусгай архив Хилийн цэргийг удирдах газрын даргын 1994 оны 155 дугаар тушаалаар байгуулагдсан. Үйл ажиллагаа нь Монгол улсын Архивын тухай хууль, Төрийн архивын ажлын үндсэн заавар болон хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул 2005 онд Үндэсний архивын газраас, Хилийн Цэргийн Төв Архивт “Төрийн архив”, 2022 онд Монгол Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд холбогдох баримтын эх хувийг улсын хэмжээнд төвлөрүүлэн байнга хадгалах “Хилийн цэргийн тусгай архив” хэмээн тодорхойлж тус тус батламж олгосон. Тус архив нь Монгол Улсын хилийн түүхэнд холбогдох баримт болон Хил хамгаалах ерөнхий газар, түүний харьяа газар, хэлтэс, албаны үйл ажиллагааны явцад үүссэн баримтуудыг Хил хамгаалах байгууллагын хэмжээнд төвлөрүүлэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлд заасны дагуу сан хөмрөг бүрдүүлэх, нөхөн бүрдүүлэх, ашиглуулах, хадгалах, хамгаалах эрх үүргийг хэрэгжүүлдэг Монгол Улсын хилийн түүхэнд холбогдох цаасан болон цахим сангийн нийт 70 гаруй хөмрөгийн 60000 гаруй баримтыг хадгалан хамгаалж, сан хөмрөгийг бүрдүүлэх, ашиглуулах, цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Үйлчилгээний талаар: Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжийн дагуу байгууллага, иргэдийн хүсэлтээр Хил хамгаалах байгууллагад ажилласан жилийн лавлагаа, цалингийн тодорхойлолт, тушаал, шийдвэрийн хуулбар, хугацаат цэргийн алба хаасан лавлагааг тус тус гарган өгч, архивын баримтыг уншлагын танхимаар түр олгон ашиглуулж, үйлчилдэг. Төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэл хяналтын систем /E-mongolia/-д холбогдон **дөрвөн төрлийн үйлчилгээний** хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэж байна.

Тусгай архиваас байгууллага, иргэдийн хүсэлтийн дагуу 1240, цахимаар 1163, нийт 2403 лавлагаа, тодорхойлолт, 344 хуулбар гарган өгч, 69 иргэн, алба хаагчдад 517 архивын баримтыг бүртгэлээр олгон судлуулж, ирсэн 110, явсан 58 албан бичгийг хүлээн авч, тогтоосон хугацаанд шийдвэрлэж, хяналт тавин ажилласан.

Ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр: Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/13 дугаар тушаалаар баталсан “Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл”-д тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйл ажиллагаандаа 4 төрлийн программыг нэвтрүүлэн ашиглаж, Хилийн цэргийн 23 ангид хүчин чадал сайтай иж бүрэн компьютер, 35 анги, салбарт 2 ТВ /террабайт/-ын багтаамжтай зөөврийн хатуу дискээр хангаж, архив, бичиг хэргийн ажилтнуудын техник хэрэгслийг сайжруулсан. Хил хамгаалах ерөнхий газрын өргөтгөлийн 2 давхарт Тусгай архивыг нүүлгэн шилжүүлж, зориулалтын дагуу төхөөрөмжлөн тохижуулж, хадгаламжийн сангийн талбай 2, нягтруулсан шүүгээний тоо 4 дахин нэмэгдэж, архивын үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрэн хангагдаж, албан тушаалтнуудын ажиллах таатай орчин бүрдсэн. Өнөөдрийн байдлаар сан хөмрөгийн баримтын дүүргэлт 40 хувьтай, 10 жилийн нөөцтэй байна. Архивын ерөнхий газар болон Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран цахим сургалтыг хилийн цэргийн анги, тусгай салбаруудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудад 2 удаа зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Алба хаагчдыг сургаж бэлтгэх талаар: Хилийн цэргийн анги, тусгай салбаруудын нууц хамгаалах ажилтнуудын арга зүйн нэгдсэн цугларалт явуулах үед Архивын ерөнхий газар болон Тагнуулын тусгай архивын мэргэжилтнүүдээр 4 цагийн сургалт явуулсан. Архивын ерөнхий газраас зохион байгуулдаг мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтад хилийн анги, тусгай салбаруудаас жилд дунджаар 40-50 архив, бичиг хэргийн ажилтныг суралцуулдаг бөгөөд 2024 онд 09 дүгээр сарын байдлаар 12 ажилтан онлайнаар суралцаад байна. Архивын баримтаас 5 хөмрөгийн 118 хадгаламжийн нэгж, 29677 хуудас баримтад нягтлан шалгалт хийж, цахим санд холбосон. Хилчин генералуудын “Дархан хилийн цадиг” 22 нэвтрүүлгийг хүлээн авч, нягтлан шалгалт хийж, цахим санд холбосон.

Монгол Улсад генерал цол бий болсны 80 жилийн ойн хүрээнд Хил хамгаалах байгууллагаас төрсөн 29 генерал цолтныг хүлээн авах хүндэтгэлийн арга хэмжээнд “Хилчин генерал” гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж, алба, үйл ажиллагааны ололт амжилтыг сурталчилсан.

3.4 Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн сан”-аас лавлагаа, мэдээлэл олгосон байдал

Хил хамгаалах байгууллагаас улсын хилээр нэвтэрсэн лавлагаа, мэдээллийг эрх бүхий байгууллага, иргэдэд хууль, тогтоомжид заасан эрх зүйн үндэслэлээр олгож байна.

Төрийн мэдээлэл солилцох цахим систем “E-Doc” болон албаны и-мэйл хаягаар лавлагаа, мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авч 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар 7040 байгууллагын хүсэлтийг хүлээн авч 594825 иргэн, 3479 тээврийн хэрэгслийн лавлагаа мэдээлэл олгосон бол иргэдээс гаргасан хүсэлтийн дагуу E-Mongolia цахим системээр дамжуулан 381, хүсэлт гаргасан 7476, нийт 7857 иргэнд лавлагаа, мэдээлэл олгож үйлчилсэн. Эрх бүхий байгууллага, иргэдээс Хил хамгаалах байгууллагаас олгож байгаа лавлагаа, мэдээлэлтэй холбоотой санал, гомдол гаргаагүй байна.

3.5 Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах 2024 оны ажлын жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
	2	3	4
Нэг. Хууль, эрх зүйн хүрээнд			
	Улсын хилд 5-аас дээш жил алба хаасан офицер, ахлагч нарт нэг удаагийн мөнгөн урамшуулал олгох	Улсын хилд 5-аас дээш жил алба хаасан офицер, ахлагч нарт мөнгөн урамшуулал олгох судалгааг нэгтгэн, нийт 535 албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тушаалыг албажуулсан	95
	Алслагдсан хилийн цэргийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нарын ажил эрхлээгүй гэр бүлийн гишүүдэд тэтгэмж олгох	Алслагдсан хилийн отряд, заставд ажиллаж байгаа офицер, ахлагч нарын 888 ажил эрхлээгүй гэр бүлийн гишүүдэд тэтгэмж олгох судалгааг нэгтгэн, улирал тутам албан хаагчийн ажил эрхлээгүй гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгох тушаалыг албажуулсан	98
	Офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих мөнгөн тусламж олгох	Алслагдсан хилийн цэргийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдүүдийн судалгааг нэгтгэн, улирал тутам албан хаагчийн сургуулийн насны 6654 хүүхдэд тэтгэмж олгох тушаалыг албажуулсан	98
Хоёр. Эрүүл мэндийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж, хилчдийн амралт, сувиллын газрыг нэмэгдүүлэн өвчлөлийг бууруулах чиглэлээр:			
	ХХЕГ болон Хилийн цэргийн 0165, 0130, 0214, 0198, 0306, 0132, 0285, 0243, 0101, 0287, 0275 дугаар ангиудын алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэг, оношилгоонд хамруулах	Хил хамгаалах ерөнхий газрын даргын “Урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах тухай” 2024 оны А/09 дүгээр тушаалаар Хил хамгаалах ерөнхий газар, хилийн цэргийн 11 (0165, 0130, 0214, 0198, 0306, 0132, 0285, 0243, 0101, 0287, 0275) ангид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж, нийт 2803 алба хаагчид хамрагдсан	100
	Явуулын оношилгооны автомашинд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж авч тоноглон, үйл ажиллагаанд ашиглах	ХХЕГ-ын даргын зөвлөлийн 2024.04.17-ны өдрийн 5-р хуралдааны шийдвэрээр явуулын оношилгоо, шинжилгээний автомашины тоног төхөөрөмж худалдан авах гэж өөрчилсөн. Мөн даргын 2024 оны А/24-р тушаалаар батлагдсан Үнэлгээний хорооны 14-р хурлаар БНХАУ-аас “Higer” загварын автобус худалдан авахаар шийдвэрлэж, 9 сард хүлээн авсан. Явуулын оношилгоо,	94

		шинжилгээний автомашинд шаардлагатай тоног төхөөрөмжийн тооцоо, судалгаа гаргах ажлыг ТТАХНЭ-тэй хамтран зохион байгуулж байна	
	Хилчдийн нийгмийн хамгаалал хөтөлбөрийн хүрээнд хилийн цэргийн ангиудын сувилалд бие бүрэлдэхүүнийг хамруулах	Онцгой байдлын ерөнхий газрын “Жаргалант” сувилалд 9, хилийн цэргийн 7 (0165, 0129, 0132, 0311 0245, 0287, 0275) ангийн улирлын чанартай сувилалд 327, нийт 334 алба хаагчийг гэр бүлийн хамт хэвтүүлэн, сэргээн засах эмчилгээнд хамруулсан	100
	Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар зохион байгуулж буй “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах	Хилийн цэргийн мод үржүүлгийн агропарк, төвүүдэд модлог харандаа мөчрөөр (улиас, бургас, сухай) 719,700, 7 төрлийн мод, сөөгний үр (нарс, шинэс,хайлаас, чацаргана, шархуйс, агч, заг) 159,5 кг-ийг тарьж, 15 анги, салбар 14 нэр төрлийн 48,849 ширхэг суулгацыг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Хил хамгаалах байгууллагын “Ногоон хэрэм” төслийн хэрэгжилтийг хангаж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Ойн газар”, “Эрдэнэс тавантолгой” ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 285,700 ширхэг навчит болон шилмүүст модыг хамгаалалтын ойн зурвас байгуулах 80,0 га, заган ой нөхөн сэргээх 70,0 га, булаг, шанд хамгаалах ойжуулалтын 4,5 га, хотын ойн санг нэмэгдүүлэх 35,0 га талбайд тус тус хээрийн ойжуулалтад шилжүүлэн тарих ажлыг зохион байгуулсан.	100
	Хилчдийг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх, сэтгэл зүйн эерэг хандлага төлөвшүүлэх аяныг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулах	Хил хамгаалах байгууллагын хэмжээнд зохион байгуулж буй “Бүжиг бидний соёл”, аяны хүрээнд хилийн цэргийн анги, тусгай салбарын алба хаагчдыг 18 төрлийн бүжгийг сургаж, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдал, илүүдэл жингээс татгалзах, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх, сэтгэл зүйн эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор төрөл бүрийн аянуудыг зохион байгуулсан	93
	Хилийн цэргийн 0214, 0168, 0129, 0184, 0306, 0245, 0277, 0275 дугаар ангиудын 16 салбаруудад 800 литрийн багтаамжтай хөлдөөгч худалдан авч албанд ашиглах	Хилийн цэргийн 0214, 0168, 0129, 0184, 0306, 0245, 0277, 0275 дугаар ангиудын 16 салбаруудад 800 литрийн багтаамжтай хөлдөөгчийг нийт 27.2 сая төгрөгийн төсвөөр худалдан авч албанд ашиглах ажлыг зохион байгуулсан	100
	Хилийн цэргийн 4 анги, салбаруудын хөргүүр суурилуулах, засварлах (Хилийн цэргийн 0101, 0243, 0257 дугаар ангийн 0312, 0295, 0117 дугаар салбарууд)	Хилийн цэргийн 0253 дугаар ангид мах, махан бүтээгдэхүүн хадгалах 40м3, 0243, 0101, 0257, 0198 дугаар ангиудад 10м3 багтаамжтай хөргүүрүүдийг нийт 105 сая төгрөгийн төсвөөр тус тус суурилуулж ашиглалтад оруулсан	100
	Хийн халаалтад шилжсэн салбаруудыг хийн тоног төхөөрөмж, сав хэрэглэлээр хангах (Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн 4, 0168 дугаар ангийн 7, 0184 дүгээр ангийн 5, 0146 дүгээр ангийн 2, 0198 дугаар ангийн 6, 0306 дугаар ангийн 6 нийт 30 салбар)	Хийн халаалтад шилжсэн хилийн цэргийн 0130 дугаар ангийн 6 салбар, 0214 дүгээр ангийн 4 салбар, 0168 дугаар ангийн 7 салбар, 0184 дүгээр ангийн 5 салбар, 0146 дугаар 2 салбар, 0198 дугаар ангийн 6 салбар, 0306 дугаар ангийн 6 салбар, нийт 36 салбарт хийн 3 тоног төхөөрөмж болон 6 төрлийн сав хэрэглэлээр хангах нийт 82.3 сая төгрөгийн төсвийг олгож хангалтыг зохион байгуулсан	100
	Хилийн цэргийн 7 ангийн 19 салбаруудад ариун цэврийн байгууламж суурилуулах	Хилийн цэргийн 10 ангийн төвийн орон сууцны хотхон, 10 салбаруудад 29 иж бүрэн ариун цэврийн байгууламж суурилуулсан	92
0	Хилийн цэргийн 24 анги, тусгай салбаруудыг сав хэрэглэлээр хангах	Хилийн цэргийн 24 анги, тусгай салбаруудад 79.6 сая төгрөгийн 12 төрлийн сав хэрэглэл худалдан авах төсвийг олгож хангалтыг зохион байгуулсан	100
Гурав.Хувь хүний хөгжлийг дээшлүүлэх сургалтын чиглэлээр:			
	Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнийг 2024 онд сургах, давтан сургах мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө гаргаж, алба хаагчдын албаны ур чадварыг нэмэгдүүлэх	“Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын мэргэшүүлэх, давтан сургах сургалтын 2024 оны төлөвлөгөө”-ний дагуу 79 нэр төрлийн сургалтад 4176 алба хаагчийг хамруулсан	92.2
	Залуучуудын хөгжлийн цахим төвийг хилийн цэргийн анги,	Хилийн цэргийн 0131, 0168, 0184, 0132 дугаар анги “Цахим залуучуудын хөгжлийн төв”-ийг нээн ажиллуулж,	97

	тусгай салбаруудад байгуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх	QR кодыг үүсгэн алба хаагчдад үйлчилж, мэргэжил сонголт, сэтгэл зүйн үйлчилгээ, хууль зүйн зөвлөгөө, цахим номын сан болон бусад хэрэгтэй зөвлөгөө, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн хилийн цэргийн 0165 дугаар анги Харуул хамгаалалтын салбарт хугацаат цэргийн алба хаагчдад зориулан “E sport”-ийн өрөөг 8.000.000 төгрөгөөр шинээр тохижуулж туршилтын журмаар ашиглаж эхлүүлсэн	
.3	Гэр бүлийн боловсрол, хувь хүний хөгжил, ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, сургагч багш бэлтгэх	Хилийн цэргийн 0165, 0214, 0131, 0168, 0129, 0108, 0184, 0146, 0198, 0306, 0132, 0285, 0311, 0245, 0243, 0101, 0218, 0253, 0252, 0303 дугаар ангиуд орон нутгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газартай хамтран бие бүрэлдэхүүнд “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хувь хүний харилцаа хандлага, ёс зүй”, “Хүүхэд хамгаалал”, “Ургийн бичгийн хөтлөлт”, “Гэр бүлийн боловсрол”, “Хүүхдийн хөгжил, боловсрол”, “Хувь хүний манлайлал”, “Аав ээж байхын учир”, “Гэр бүлийн харилцааны асуудлууд”, “Хайрын 5 хэл”, “Цагийн менежмент, “Гэр бүл, Харилцаа”, “Ажлын байрны стресс”, “Гэр бүлийн, замын хөдөлгөөн”, “Хувь хүний хөгжил”, “Тамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Аавуудын харилцаа” “Гэр бүлийн мөн чанар” сэдвүүдээр нийт 45 удаагийн багц сургалтуудыг зохион байгуулсан -“Гэр бүлийн сургагч багш” бэлтгэх сургалтад хилийн цэргийн 0198, 0306, 0285, 0311, 0245, 0243, 0101 дүгээр ангиудын 11 алба хаагч хамруулсан	100
	Хүүхэд хамгааллын чиглэлээр сургагч багш бэлтгэх	Хилийн цэргийн 0214, 0166, 0131, 0168, 0198, 0306, 0285, 0311, 0245, 0277, 0257, 0243, 0101, 0287, 0252 дугаар ангиуд орон нутгийн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран “Хүүхэд харагчийг бэлтгэх”, сургалтад 51 алба хаагчдыг хамруулсан	100
	Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Хилийн цэргийн 0165, 0214, 0166, 0131, 0108, 0146, 0132, 0245, 0286, 0243, 0164, 0253, 0288 дугаар ангиудын 17 албан хаагчийг Хангалт үйлчилгээний тасгийн үйлчлэгчээр ажиллуулдаг бөгөөд эмчилгээнд явахад нь 2 удаа 7-14 хоногийн цалинтай чөлөө олгон 4-6 цагаар ажиллуулж, ар гэрт нь нүүрс, түлээ болон орон сууцаар хангаж, дэмжлэг үзүүлсэн. Мөн “Чухал амжилт” сургалтын төвд 1 алба хаагчийг тогоочийн сургалтад хамруулсан	98
	Алдарт эхийн одонтой болон өрх толгойлсон олон хүүхэдтэй албан хаагчдын амьдралын байдлыг харгалзан өрхийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Хилийн цэргийн 0166, 0131 дүгээр ангиуд өрх толгойлсон олон хүүхэдтэй 2 алба хаагчийн амьдралын байдлыг харгалзан үзэж орон сууцны урьдчилгаа болгож тус бүр 5 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн. Хилийн цэргийн 14 ангиудын өрх толгойлсон олон хүүхэдтэй 55 алба хаагчдад хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан өрх толгойлсон алба хаагчдын хүүхдэд хичээлийн иж бүрэн хэрэгсэл, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд талх, хэрчсэн гурил зэргийг өдөр бүр шинээр боловсруулан зах зээлийн ханшнаас хямд үнээр шинэхэн бүтээгдэхүүнийг худалдаалах, түлээ, нүүрс, 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дэмжлэг үзүүлсэн	95
<i>Дөрөв. Албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр:</i>			
	ХХЕГ-ын өргөтгөл, хилийн цэргийн зарим анги, тусгай салбаруудад тавилга хэрэгслээр хангах	ХХЕГ-ийн байрны А, Б, В корпуст 4 нэр төрлийн 140 ширхэг, ХЦ-ийн 0275-р ангид 20 ширхэг ширээ, 0131-р ангийн Гашуунсухайтын боомтод өрөө, тасалгааны тавилга, шалгагчийн 4 кабин, Зорчигчийн мэдээллийн төвд 2 нэр төрлийн 18 ширхэг тавилга, 20 ширхэг албаны ширээ, хувцасны шүүгээг ХЦ-ийн 0252-р ангийн үйлдвэр технологийн цехэд үйлдвэрлүүлж, “Долоон болдог” ХХК-аас 17 нэр төрлийн 111 ширхэг тавилга хийлгэж, “Есөн мөнх сүлд” ХХК-аас 13 нэр төрлийн 321 ширхэг тавилга худалдан авч, нийт 607 ширхэг тавилга, хэрэгслийн хангалт хийсэн -ХЦ-ийн 0285-р ангийн Хөх эрэг, Улаанхудаг, 0306-р ангийн Буйр, Булан дэрс, Улаан худгийн заставуудын гэрээт цэргийн байрны 177 ширхэг тавилга	98

		хэрэгслийг хийж гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 95 хувьтай байна	
	ХХЕГ-ын хүлээлгийн танхимын тохижилт, 1-5 давхрын өрөө тасалгааны засвар	ХХЕГ-ын А, Б корпус, удирдлагын төв, дэд дарга болон газрын дарга нарын албаны 78 өрөө тасалгаанд засвар үйлчилгээ хийж гүйцэтгэсэн	100
	Хууль, зүй дотоод хэргийн салбарын "Албан хаагч бүрд орон сууц" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн удирдлагуудтай хамтран орон сууцны төсөл, хөтөлбөрт алба хаагчдыг хамруулах	"Албан хаагч бүрд орон сууц" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн удирдлагуудтай хамтран орон сууцны төсөл, хөтөлбөрт Хилийн цэргийн 14 анги, тусгай салбарын алба хаагчдыг Улаанбаатар хотод 30, орон нутагт 13 алба хаагчдыг ипотекийн зээлд хамруулсан.	97
	Хилийн цэргийн 0184 (Сайн худаг 5хз), 0287 (Хэрийн гол 5хз), 0275 (Шиврийн-Ам 2хз) дугаар ангиудын заставуудад албаны байр шинээр барих	Хилийн цэргийн 0287 дугаар ангид засварын ажлын зураг төслийг хүргүүлэн 80.0 сая төгрөгийн санхүүжилт, 0184, 0275 дугаар ангиудын албаны байруудыг тус тус бүр 60.0 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр барин хугацаанд нь дуусгаж ашиглалтад бүрэн оруулсан.	100
	Хилийн цэргийн 0146, 0286 дугаар ангиудын төвд халуун усны барилга шинээр барих	Хилийн цэргийн 0146, 0286 дугаар ангийн төвд 2 саун, 5 дүүш, үсний өрөөтэй халуун усыг шинээр барьж ашиглалтад оруулсан.	100
	Хилийн цэргийн 0131, 0184, 0146, 0277, 0257, 0287 дугаар ангиудын 11 салбарт /5-10 квт/ нарны цахилгаан үүсгүүр суурилуулах	Ажлын зураг төсөл хийгдэж, материалын үнийн судалгааг гарган, санхүүжилтийг 2024 оны 04 дүгээр сард олгосон. ХЦ-ийн 0146 дугаар ангийн 3, 0184 дүгээр ангийн 2, 0277 дугаар ангийн 1, 0243 дугаар ангийн 1 салбарт 10 кВт-ын, 0257, 0287-р ангийн тус бүр 1 салбар 5 кВт-ын, нийт 9 салбарт нарны цахилгаан үүсгүүр суурилуулсан. Хилийн цэргийн 0214, 0131-р ангиудын 2 салбарт 10 кВт-ын нарны цахилгаан үүсгүүр суурилуулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.	100
	Хилийн цэргийн 0166 дугаар ангийн Шивээ хүрэнгийн 7хз-т 24 айлын орон сууц шинээр барих	Хилийн цэргийн 0166 дугаар ангийн Шивээ хүрэн боомтод (0324 дүгээр салбарт) барих 24 айлын орон сууцны бэлтгэл хангах, тооцоо судалгааны ажил явагдаж байна	90
	Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн Бүргэдэй-Уул 3 дугаар хилийн заставт 8 айлын орон сууцыг дуусгах (төвлөрсөн халаалттай)	Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн 0312 дугаар салбарт алба хаагчдын 8 айлын орон сууцны барилгын ажлыг дуусган ашиглалтад оруулж, Сэлэнгэ аймгийн төвлөрсөн халаалтад холбосон.	100
	Хилийн цэргийн 0306 дугаар ангийн төвд 8 айл, 0198 дугаар ангийн Хар хоньт 3хз-т 9 айл, 0132 дугаар ангийн Хавирга 5хз-т 8 айл, 0245 дугаар ангийн Боршоо 5хз-т 4 айлын орон сууцыг тус бүр шинээр барих	Хилийн цэргийн 0306 дугаар ангийн 8 айлын орон сууцны шинээр барьж, барилгын ажил 85 хувьтай, 0132 дугаар ангийн орон сууц барих барилгын засварын материалыг татан авч, барилга засварын ажлыг эхлүүлсэн. Хилийн цэргийн 0198 дугаар ангийн 0190 дүгээр салбар, 0245 дугаар ангийн 0333 дугаар салбарт 33х9 хэмжээтэй 8 айлын орон сууцыг шинээр барьж ашиглалтад оруулж, дэд бүтцийг бүрэн шийдэж халаалт, халуун устайгаар ашиглалтад оруулсан.	100
Тав.Ахлагчийн жилийн ажлын чиглэлээр:			
	Ахлагчийн жилтэй холбогдуулан 120 алба хаагчдад газар олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Хилийн цэргийн 16 ангиуд газар эзэмших хүсэлт гарсан 119 алба хаагчдад газар олгуулах асуудлыг шийдвэрлэж, газар эзэмших батламжийг олгуулсан	100
Зургаа.Хилчдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, хувийн эзэмшлийн газар, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлж, гэр бүлийн гишүүдийн хөгжлийг сайжруулах чиглэлээр:			
	Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийг Олон улсын найрамдал зуслан болон бусад хүүхдийн зуслантай хамтран амраах ажлыг зохион байгуулах	Хил хамгаалах ерөнхий газар, 0165, 0131, 0108, 0184, 0311, 0277, 0243, 0252, 0253 дугаар ангиуд олон улсын найрамдал зуслангийн I ээлжид алба хаагчдын 26 хүүхэд, орон нутгийн хүүхдийн зусланд 59, нийт 85 хүүхдүүдийг амраасан.	98
	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдран суралцаж буй хилчдийн хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүүхэд хамгааллыг үйлчилгээнд хамруулах	Хилийн цэргийн 0130, 0166, 0129, 0198, 0285, 0311, 0277, 0286 дугаар ангиудын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр болон айлд амьдардаг 77 хүүхэдэд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хүндэтгэлийн зоог барьж, гарын бэлэг, 1 дүгээр ангид элсэн орсон хүүхдүүдэд хичээлийн иж бүрэн хэрэгсэл, эцэг, эхэд 1 сарын цалинтай чөлөө олгосон. Мөн сэтгэл зүйн зөвлөгөө, халуун ус, үсчнээр үйлчилж, эмэгтэйчүүдийн зөвлөл,	95

		ахлагчийн зөвлөлөөс уулзалт, ярилцлагыг зохион байгуулж ажилласан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, алба хаагчдын ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангах зорилгоор орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газраас зохион байгуулж буй “Гэртээ эрт харья” аяны хүрээнд 7 хоног бүр алба хаагчдын хүүхдүүдэд ангийн соёлын төвд кино үзүүлэх, хүүхдийн явуулын номын сан аялуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн	
	Улаан загалмайн дунд шатны хороодтой хамтран хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохион байгуулах	Хилийн цэргийн 0108, 0184, 0306, 0132, 0285 0245, 0101, 0151, 0245, 0253, 0218 дугаар ангиуд аймаг, орон нутгийн Улаан загалмайн дунд шатны хороодтой хамтран хүмүүнлэгийн үйл ажиллагааг зохион байгуулж гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдад ажлын 50 хос ажлын хувцас, 5 ширхэг хөдөлмөр хамгааллын ком хувцас, 30 ширхэг хөнжил, гудас, 5 баглаа /прес/ хувцас хэрэглэл зэргийг өгсөн. Мөн амьжиргааны түвшин доогуур 6 алба хаагчдад хүнс, эд материал, 0-6 сартай 7 хүүхдийн нярайн хувцас хэрэглэл, 20 хүүхэд хувцас, хичээлийн иж бүрэн хэрэгслээр туслалцаа үзүүлсэн. Улаан загалмайн гишүүнчлэлд 328 албан хаагч элсэн орж 2.7 сая төгрөгийн татвар төлсөн.	96
	Байгууллагын дэргэд салбар цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээг нэмэгдүүлэх	Хилийн цэргийн 13 /0165, 0214, 0166, 0131, 0168, 0198, 0132, 0285, 0311, 0245, 0277, 0287/ дугаар ангиуд байгууллагын дэргэд 5 салбарт цэцэрлэгийн бүлэг, 26 салбарт хүүхэд харах үйлчилгээ, 1 салбарт гэр цэцэрлэгийг тус тус ажиллуулж байна.	95
	Хилийн цэргийн 0130, 0146, 0245, 0286, 0267 дугаар тусгай салбаруудад 4 болон 8 айлын орон сууц шинээр барих	Алба хаагчдынхаа нийгмийн баталгааг хангах амьдрах таатай орчин бүрдүүлэх зорилгоор хилийн цэргийн 0130, 0146, 0245, 0286, 0267 дугаар тусгай салбаруудад 4 болон 8 айлын орон сууц барьж ашиглалтад оруулан дэд бүтцийг бүрэн шийдсэн.	100
	Албан хаагчдын гэр бүлийг орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамруулан, өрхийн үйлдвэрлэл явуулах, туслах ахуй эрхлэлтийг дэмжих	Албан хаагчдын 31 гэр бүлийг орон нутагт хэрэгжүүлж байгаа Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газраас хэрэгжүүлж буй “Нутгийн дэм”, “Залуучуудын гарааны бизнесийг дэмжих STARUP”, Политехникийн коллежтой хамтран “Хүлэмжийн аж ахуй, фермер”, “Эсгий урлал”, “Гар урлал”, “Давсан урлал” гэх мэт төсөл, хөтөлбөрт хамруулан, өрхийн үйлдвэрлэл явуулах, туслах аж ахуй эрхлэлтийг дэмжих ажлуудыг зохион байгуулсан	96
	Ердийн галлагаатай гэр, байранд амьдарч буй албан хаагчдад түлээ нүүрс авахад дэмжлэг үзүүлэх	Хилийн цэргийн 0130, 0214, 0131, 0108, 0184, 0132, 0245, 0277, 0257, 0286, 0243, 0275, 0164, 0253, 0288 дугаар ангиуд ердийн галлагаатай гэр, байранд амьдарч буй 449 албан хаагчдад 844 тонн нүүрс, 84 м ³ мод татахад зориулж, хөнгөлөлттэй үнээр автомашинаар үйлчлэн дэмжлэг үзүүлсэн.	90
	Хилийн ангиудын туслах аж ахуйгаас бэлтгэсэн мах болон хүнсний бүтээгдэхүүнийг албан хаагчдад хөнгөлөлттэй үнээр худалдаалах	Алба хаагчдын нийгмийн асуудлыг дэмжих ажлын хүрээнд 2024 онд нийт 1748 алба хаагчид хүнсний ногоо, мах олгож дэмжлэг үзүүлсэн	97
Долоо.Ахмад хилчдийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр:			
	Цэргийн тэтгэвэрт гарч байгаа офицер, ахлагч нарын талаар төрөлх орон нутгийнх нь засаг захиргааны нэгжид хүндэтгэлийн захидал илгээж, дэмжлэг үзүүлэх	Цэргийн тэтгэвэрт гарсан 27 алба хаагчдад төрөлх орон нутгийн засаг захиргаанд хүндэтгэлийн захидал хүргүүлж, Газрын харилцаа хот төлөвлөлтийн газартай хамтран алба хаагчдад амьдрах орон нутагт нь газар газар олгуулж дэмжлэг үзүүлсэн	92
	Цэргийн тэтгэвэрт гарах албан хаагчдад биеэ эмчлүүлэх, амьдрал ахуйгаа зохицуулахад нь 1 сар хүртэлх хугацаатай цалинтай чөлөө олгох	Цэргийн цэргийн тэтгэвэрт гаргасан 115 алба хаагчдад биеэ эмчлүүлэх, амьдрал ахуйгаа зохицуулахад 1 сар хүртэлх хугацаатай цалинтай чөлөө олгосон	95
	Орон нутгийн байгууллагуудтай хамтран ахмад хилчдийн эзэмшсэн мэргэжил, ажлын дадлага, туршлагад тохирсон ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	Орон нутгийн байгууллагатай хамтран 31 ахмад хилчнийг өөрийн эзэмшсэн мэргэжилд тохирсон ажлын байраар хангуулан ажилласан	90

	Ахмад хилчдэд зориулан сайн үйлсийн аян, өрнүүлж нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх	Хилийн цэргийн 0165, 0214, 0131, 0108, 0306,0132, 0243, 0218 дугаар ангиуд 10 ахмад хилчинд 3,950,000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн. “Халуун сэтгэл, амтаг бууз”, “Сайхан сэтгэл түгээ” зэрэг аяныг зохион явуулж нийт 25 ахмад хилчинд сэтгэлийн дэм өгч, 45 тонн нүүрс, 1 сарын хүнсний хэрэгцээг хангаж нийгмийн асуудлыг шийдвэрлэн дэмжлэг үзүүлсэн. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улсын “Южин Оптисал” нүдний эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 5 ахмад хилчнийг үнэ төлбөргүй хамруулсан	95
	Хил хамгаалах байгууллагын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй амралт, сувиллын газарт ахмад хилчдийг хөнгөлөлттэй үнээр амраах	Хилийн цэргийн 0131, 0168, 0108, 0132, 0285, 0311, 0245, 0277, 0257, 0275, 0224, 0253, 0288 дугаар тусгай салбарууд Хил хамгаалах байгууллага болон орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй амралт, сувиллын газарт 286 ахмад хилчнийг хөнгөлөлттэй үнээр амрааж сувилуулсан	97
Хэрэгжилт			96.9

3.6 Хилчдийн нийгмийн хамгаалал 2024 хөтөлбөр”-т оруулах нэмэлт өөрчлөлт оруулсан төлөвлөгөөний хэрэгжилт

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
2.Эрүүл мэндийн бүх шатны байгууллагуудтай хамтран ажиллаж, хилчдийн амралт, сувиллын газрыг нэмэгдүүлэн өвчлөлийг бууруулах чиглэлээр:			
1	Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн санаачилгаар зохион байгуулж буй “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах	Хилийн цэргийн мод үржүүлгийн агропарк, төвүүдэд модлог харандаа мөчрөөр (улиас, бургас, сухай) 719,700, 7 төрлийн мод, сөөгний үр (нарс, шинэс,хайлаас, чацаргана, шархуйс, агч, заг) 159,5 кг-ийг тарьж, 15 анги, салбар 14 нэр төрлийн 48,849 ширхэг суулгацыг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. -Хил хамгаалах байгууллагын “Ногоон хэрэм” төслийн хэрэгжилтийг хангаж Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Ойн газар”, “Эрдэнэс тавантолгой” ХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 285,700 ширхэг навчит болон шилмүүст модыг хамгаалалтын ойн зурвас байгуулах 80,0 га, заган ой нөхөн сэргээх 70,0 га, булаг, шанд хамгаалах ойжуулалтын 4,5 га, хотын ойн санг нэмэгдүүлэх 35,0 га талбайд тус тус хээрийн ойжуулалтад шилжүүлэн тарих ажлыг зохион байгуулсан.	100
2	Хил хамгаалах байгууллагын хариуцсан хэсэгт байрлах эрүүл мэндэд тусгай байгалийн өвөрмөц тогтоц бүхий (рашаан, элс, шавар)-т түшиглэн амралт сувиллын газруудын үйл ажиллагааг өргөтгөн, харилцан ажиллагаатай байгууллагуудын амралт, сувиллын газар бие бүрэлдэхүүнийг хөнгөлөлттэй үнээр амраах	-Онцгой байдлын ерөнхий газрын “Жаргалант” сувилалд 9, хилийн цэргийн 7 (0165, 0129, 0132, 0311 0245, 0287, 0275) ангийн улирлын чанартай сувилалд 327, нийт 334 алба хаагчийг гэр бүлийн хамт хэвтүүлэн, сэргээн засах эмчилгээнд хөнгөлөлттэй үнээр амраасан -Хилийн цэргийн 0131, 0168, 0108, 0132, 0285, 0311, 0245, 0277, 0257, 0275, 0224, 0253, 0288 дугаар тусгай салбарууд Хил хамгаалах байгууллага болон орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй амралт, сувиллын газарт 286 ахмад хилчдийг хөнгөлөлттэй үнээр амрааж сувилуулсан.	100
3	Хилчдийг хөдөлгөөний дутагдаас урьдчилан сэргийлэх, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх, сэтгэл зүйн эерэг хандлага төлөвшүүлэх аяныг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулах	Хил хамгаалах байгууллагын хэмжээнд зохион байгуулж буй “Бүжиг бидний соёл”, аяны хүрээнд хилийн цэргийн анги, тусгай салбарын алба хаагчдыг 18 төрлийн бүжгийг сургаж, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний дутагдал, илүүдэл жингээс татгалзах, эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх, сэтгэл зүйн эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгоор төрөл бүрийн аянуудыг зохион байгуулсан.	93

4	Хил хамгаалах байгууллагын хэмжээнд сонголтын хоолны системийг нэвтрүүлэх	Хилийн цэргийн анги, тусгай салбаруудад гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн хооллолтыг 7 хоногийн 3-5 өдөр сонголттой хооллолтоор, 2 өдрийг өөртөө үйлчлэхээр зохион байгуулж хэвшсэн.	
Дөрөв.Албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин, албаны орон сууцны хангалт нөхцөлийг сайжруулах чиглэлээр:			
5	ХХЕГ-ын өргөтгөл, Монгол Улсын хил хамгаалалтын удирдлагын төв, Хилийн цэргийн төв архивын барилга барих	<p>“Хил хамгаалалтын шуурхай удирдлагын төв”-ийг байгуулж, ШУДШХ-г 2024.03.01-ний өдөр байр танхим, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.</p> <p>-Монгол Улсын хил хамгаалалтын нэгдсэн удирдлагын төв”-ийн бүтэц, орон тоо, ажиллах журмыг боловсруулж, удирдлагад танилцуулсан.</p> <p>-Монгол Улсын ХЗДХЯ, ХХБ, БНЭУ-ын Дотоод хэргийн яам, Хилийн аюулгүй байдлын хүчин хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Улсын хил хамгаалалтын нэгдсэн удирдлагын төв”-ийг байгуулах төслийг хэрэгжүүлж, тухайн улсын “Amtrak Technologies” компаниас 2024 оны 05-р сард тоног төхөөрөмж (9 нэр төрлийн 165 нэгж техник хэрэгсэл)-ийг тусламжаар хүлээн авч, төхөөрөмжилсөн.</p> <p>-ХХЕГ-ын даргын 2024 оны А/118-р тушаалаар ХЦ-ийн тусгай архивыг өргөтгөлийн 2 давхарт нүүлгэн шилжүүлж, Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 6.20.1-д заасны дагуу архивын баримтад нэгдсэн тооллого зохион байгуулж, үр дүнг удирдлагад танилцуулсан.</p> <p>-ХЦТА-ын баримт хадгалах зориулалтын 34 шүүгээ худалдан авч, стандартын дагуу тохижуулсан</p>	100
6	Хууль, зүй дотоод хэргийн салбарын "Албан хаагч бүрт орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, аймаг сумдын удирдлагуудтай хамтран албан хаагчдад газар олгуулж, орон сууцны төсөл хөтөлбөрт хамруулах	"Албан хаагч бүрд орон сууц" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн удирдлагуудтай хамтран орон сууцны төсөл, хөтөлбөрт Хилийн цэргийн 14 анги, тусгай салбарын алба хаагчдыг Улаанбаатар хотод 30, орон нутагт 13 алба хаагчдыг ипотекийн зээлд хамруулсан.	97
7	Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүрэгт 1400 айлын орон сууц барих бэлтгэл ажлын хангах	Хил хамгаалах ерөнхий газрын эзэмшлийн газарт нийслэл хот холбогдох хууль тогтоомжийн дагуу 2500 айлын орон сууц барихаар болж санамж бичиг байгуулсан.	100
8	Хил хамгаалах ерөнхий газрын болон Улаанбаатар хүрээний хилийн цэргийн ангиудын албан хаагчдад зуслангийн газар олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	Хилийн цэргийн 16 ангиуд газар эзэмших хүсэлт гарсан 119 алба хаагчдад газар олгуулах асуудлыг шийдвэрлэж, газар эзэмших батламжийг олгуулсан	100
Тав.Хилчдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, хувийн эзэмшлийн газар, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлж, гэр бүлийн гишүүдийн хөгжлийг сайжруулах чиглэлээр:			
9	Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын хүүхдүүдийг Олон улсын найрамдал зуслан болон бусад хүүхдийн зуслантай хамтран амраах ажлыг зохион байгуулах	Хил хамгаалах ерөнхий газар, 0165, 0131, 0108, 0184, 0311, 0277, 0243, 0252, 0253 дугаар ангиуд олон улсын найрамдал зуслангийн I ээлжид алба хаагчдын 26 хүүхэд, орон нутгийн хүүхдийн зусланд 59, нийт 85 хүүхдүүдийг амраасан.	98
10	Хил хамгаалах ерөнхий газрын болон Улаанбаатар хүрээний ангиудын албан хаагчдын хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулахад дэмжлэг үзүүлэх	<p>-Хилийн цэргийн 11 анги, тусгай салбаруудын алба хаагчдын 2-5 насны хүүхдүүд Нийслэлийн дүүргүүдийн цэцэрлэгт 236 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна. Олон Улсын эрхийг хамгаалах өдрөөр “Авьяаслаг гэр бүл” өдөрлөгийг зохион байгуулж, ангийн байрлалд хүлээн авч, өдрийг зоог барьж, “Хөгжилтэй буухиа”, “Гар зургийн уралдаан” зэрэг тэмцээнийг явуулж, 443 хүүхдүүдэд гарын бэлэг, “Үндэсний соёл амралтын хүрээлэн”-д тоглох эрхийн бичиг гардуулан өгсөн.</p> <p>-Хүүхдээ цэцэрлэгт оруулахад шаардлагатай 4 алба хаагчид албан байгууллагын тодорхойлолт, 8 алба хаагчдад цэцэрлэгийн бэлтгэл хангуулахад нь</p>	100

		зориулж 1 өдрийн цалинтай чөлөө олгож дэмжлэг үзүүлсэн	
11	Хил хамгаалах байгууллагын хэмжээнд төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх	Хилийн цэргийн 0165, 0214, 0166, 0131, 0108, 0146, 0132, 0245, 0286, 0243, 0164, 0253, 0288 дугаар ангиудын 17 албан хаагчийг Хангалт үйлчилгээний тасгийн үйлчлэгчээр ажиллуулдаг бөгөөд эмчилгээнд явахад нь 2 удаа 7-14 хоногийн цалинтай чөлөө олгон 4-6 цагаар ажиллуулж, ар гэрт нь нүүрс, түлээ болон орон сууцаар хангаж, дэмжлэг үзүүлсэн. Мөн “Чухал амжилт” сургалтын төвд 1 алба хаагчийг тогоочийн сургалтад хамруулсан	98
12	Алдарт эхийн одонтой болон өрх толгойлсон олон хүүхэдтэй албан хаагчдын амьдралын аргагүй байдлыг харгалзан өрхийн орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах	Хилийн цэргийн 0166, 0131 дүгээр ангиуд өрх толгойлсон олон хүүхэдтэй 2 алба хаагчийн амьдралын байдлыг харгалзан үзэж орон сууцны урьдчилгаа болгож тус бүр 5 сая төгрөгийн буцалтгүй тусламжийг үзүүлсэн. Хилийн цэргийн 14 ангиудын өрх толгойлсон олон хүүхэдтэй 55 алба хаагчдад хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан өрх толгойлсон алба хаагчдын хүүхдэд хичээлийн иж бүрэн хэрэгсэл, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд талх, хэрчсэн гурил зэргийг өдөр бүр шинээр боловсруулан зах зээлийн ханшнаас хямд үнээр шинэхэн бүтээгдэхүүнийг худалдаалах, түлээ, нүүрс, 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр дэмжлэг үзүүлсэн.	96
Хэрэгжилтийн хувь			90.1

“Хил хамгаалах байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний “6. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, ил тод байдлыг хангах” зорилтын хүрээнд: 6.2-т туссан “Хил хамгаалах байгууллагын алба, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах” арга хэмжээг хэрэгжүүлж дараах ажлыг хийсэн. Үүнд:

- Хил хамгаалах байгууллын үйл ажиллагаагаа Bro.gov.mn, “Эх орны манаа” сонин, “Хилчин” студи, “Хилчин” сэтгүүл, “Хил хамгаалах байгууллага” цахим хуудсаар олон нийтэд тогтмол сурталчилдаг.
- “Хил хамгаалах байгууллага” цахим хуудсанд хилчдийн ололт амжилтын талаар 213 видео, 357 фото мэдээ, бусад мэдээллийн сайтуудад 37 удаа мэдээ бэлтгэн өгч, олон нийтэд сурталчилсан
- Эх орны манаа сонины 24 дугаарыг эрхлэн гаргаж, хилчдэд хүргэн, өдөр тутмын 2 сонинд 7 нийтлэл, мэдээ нийтлүүлсэн
- Шинжлэх ухаан, онол арга зүй, танин мэдэхүйн “Хилчин” сэтгүүлийн 2 дугаарыг эрхлэн гаргасан
- “Сүлдэт баганын дэргэдээс” нэвтрүүлгийн 8 дугаар, ШШГЕГ-тай хамтран “Тангараг нэгт эрчүүд”, ТВ25 телевизтэй “Танайд хоноё”, МҮОНТ-тэй “Амьдралын загвар” нэвтрүүлэг, хилчдийн албаны онцлогийг харуулсан “Аавын хүү” богино хэмжээний уран сайхны кино, хурандаа З.Хийсийн тухай “Баруун хилийн домогт хурандаа” хөрөг нэвтрүүлэг, Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ойн хүрээнд “Зарлаагүй дайны гэрч”, Хилчин генералууд, “Эх

оронтойгоо хуваалцсан амьдрал” зэрэг нэвтрүүлэг, Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачлагчаар 2024 оныг Ахлагчийн жил болгон зарласантай холбогдуулан ахлагчийн албыг сурталчилсан 9 контент бэлтгэн харилцан ажиллагаатай телевизүүдээр нэвтрүүлсэн

Цаашлаад ХХЕГ-ын даргын 2023 оны А/269-р тушаалаар томилогдсон ажлын хэсэг Улсын хилийн музейг шинэчлэхээр холбогдох зураг төсөл, тооцоо судалгааг гаргаж, засварын бараа материалыг худалдан авч, тохижилт засварын ажлууд хийгдэж байна. Улсын хилийн түүхийн танхимын ерөнхий засвар хийгдэж дууссан, үзүүлэг, дэглэлтийн ажил хийгдэж байна. Улсын хилийн музейг 2024 онд 2300 хүнд үйлчлэхээр төлөвлөснөөс 2024.11.20-ны байдлаар нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутан, сонсогч, иргэн, нийт 2100 хүнд үзүүлж, Хил хамгаалах байгууллага, хилчдийн алба, үйл ажиллагааг сурталчлаад байна.

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ бүлэг нь судалгааны эх олонлог, түүвэр, хувьсагчийг тодорхойлох, судалгааны өгөгдөл цуглуулах болон түүнд дүн шинжилгээ хийх үйл явц зэргийг тайлбарлана.

3.1. Судалгааны эх олонлог, түүврийн хэмжээ

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа хтл хамгаалах байгууллагаар тогтмол үйлчлүүлдэг иргэдийг хамруулахаар төлөвлөсөн. Судалгааны мэдээллийг 1) Хил хамгаалах Ерөнхий газар, 2) Чингис хаан” ОУ-ын нисэх буудал, 3) “Замын -Үүд” авто болон төмөр замын боомт, эдгээрт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын төлөөллийг зэрэг хүн амын хөдөлгөөн ихтэй гол байршлыг сонгон 2024 оны 10-р сарын 14-ний өдрөөс 12-р сарын 05-ны өдөр хүртэлх хугацаанд цуглуулсан. Судалгаанд тоон (асуулгын) болон чанарын (ярилцлага) судалгааны арга ашиглан өгөгдлийг цуглуулсан. Судалгаанд нийт 330 иргэн, ААН-ын төлөөлөл судалгаанд хамрагдсан. Түүврийн хэмжээг 95% найдвартай, $\pm 5\%$ хэлбэлзэлтэй Taro Yamane-гийн томьёонд үндэслэн тооцоолох замаар тодорхойлсон. Энэ томьёо нь түүврийн хэмжээг тооцоолоход ашигладаг хамгийн оновчтой тооцоолол гэж судлаачид хүлээн зөвшөөрсөн байдаг.

Чанарын судалгааг ярилцлагын арга ашиглан иргэд, ААН-ын төлөөлөл, алба хаагчидтай хийсэн. Гол зорилго нь тоон шинжилгээний арга буюу асуулгыг аргаар илрүүлсэн судалгааны үр дүнг илүү тодруулах, баяжуулах, бататгахад чиглэсэн. Түүврийг бүрдүүлэхдээ Хил хамгаалах Ерөнхий газар, Чингис хаан” ОУ-ын нисэх буудал, “Замын -Үүд” авто болон төмөр замын боомтоор үйлчлүүлж буй иргэдээс санамсаргүй байдлаар сонгон авч 18 иргэнтэй ярилцлага хийсэн. Ярилцлагын гол чиглүүлэх асуулт нь хил хамгаалах байгууллага, цаашлаад Чингис хаан” ОУ-ын нисэх буудал, “Замын -Үүд” боомтын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээ чанар, хүртээмж, хүнд суртал, шуурхай байгаа эсэх талаар иргэд, аж ахуйн нэгжийн хандлагыг тандан судалж илрүүлэхэд чиглэсэн.

3.2. Судалгааны өгөгдлийн шинжилгээний арга

2024 онд хил хамгаалах байгууллагаас үйлчилгээ авсан болон байгууллагаас хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, найдвартай үр дүнтэй, хүртээмжтэй байдал, албан хаагчийн харилцааны соёл, ёс зүй, үйлчилгээ үзүүлж байгаа орчин нөхцөлийн тав тухтай байдал, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн

хангамж хүрэлцээг үнэлүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйлчилгээг сайжруулах арга замын талаарх иргэдийн байр суурийг шинжилж үнэлэлт дүгнэлт хийлээ. Судалгааны өгөгдлийг тоон болон чанарын шинжилгээний арга ашиглан цуглуулсан. Тоон судалгаагаар гарсан үр дүнг баталгаажуулах зорилгоор оролцогчидтой ганцаарчилсан ярилцлага хийж, өгөгдлийн мэдээллийг цуглуулж судалгааны үр дүнг баталгаажуулсан. Судалгааны асуулгыг Ликертийн 5 шкалын хэмжээсийг ашиглан мэдээллийг цуглуулсан. Судалгааны цуглуулсан өгөгдөл, мэдээлэлд боловсруулалт хийхдээ нийгмийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг SPSS шинжилгээний арга ашиглан боловсруулалт хийсэн. Асуулгын хуудсыг ерөнхий удирдамжид тулгуурлан боловсруулж, үзүүлэлт бүрийг 1-маш муу, 2- муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн, 0-мэдэхгүй, хариулах боломжгүй гэсэн сонголтууд бүхий 5 хүртэл оноотойгоор боловсруулсан болно. Нийт авсан чиглэл тус бүрээр үнэлж оноог 1-5 хооронд хөрвүүлж хувиар тооцож бодно.

Судалгааны баг хэрэглэгчийн үнэлгээний судалгааг дараах үндсэн 6 чиглэл, шалгуур үзүүлэлтийн дагуу оролцогчдын асуултад хариулсан байдалд шинжилгээ хийж дүгнэсэн. Үүнд:

Зураг 1. Судалгааны шалгуур үзүүлэлт, хэмжих нэг

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжүүр	Судалгааны арга
1.	Мэдээллийн ил, тод, нээлттэй байдал	<ul style="list-style-type: none"> - хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; - хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх; - мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх; - мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх; - нийтийн мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд эрх тэгш байх; - нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай, нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх; 	Асуулга Ярилцлага
2.	Үйлчилгээний хүртээмжтэй байдал	<ul style="list-style-type: none"> - ХХБ-ыс үйлчилгээ авах боломж нөхцөл - Үйлчилгээний мэдээллийн хүртээмжтэй байдал - Үйлчилгээ үзүүлж буй цэг, ажилтнуудын хүртээмжтэй байдал 	Асуулга Ярилцлага
3.	Үйлчилгээний хүнд сурталгүй, шуурхай байдал	<ul style="list-style-type: none"> - Үйлчилгээний шуурхай байдал - Асуудлыг газар дээр нь шийдэж байгаа байдал - Тухайн үйлчилгээг хуулийн хугацаанд шийдвэрлэж байгаа байдал 	Асуулга Ярилцлага
4.	Үйлчилгээний чанартай байдал	<ul style="list-style-type: none"> - Үйлчилгээний талаарх мэдээллийн хангалттай байдал - Ажилтнуудын тоо, хүрэлцээтэй байдал - Ажилтнуудын мэргэжлийн ур чадвар 	Асуулга Ярилцлага
5.	Үйлчилгээндээ хүний эрхийг дээдэлсэн байдал	<ul style="list-style-type: none"> - Хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж буй байдал - Үйлчилгээг эрх тэгш хүргэх байдал 	Асуулга Ярилцлага

6.	Алба хаагчдын ёс зүй, ажлын ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авахад тохиромжтой байдал - Санал, гомдол илэрхийлэх боломжтой байдал - Ажилдаа мэргэшсэн байдал - Мэдлэг ур чадвар - Мэргэжлийн ур чадвар - Шударга байдал - Тэгш хандаж үйлчлэх байдал - Хариуцлагатай байдал 	Асуулга Ярилцлага
----	--	---	----------------------

ТАВ. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

5.1. Судалгаанд оролцогчдын байршил, хүн ам зүйн шинж байдал

Энэ судалгаа судлаач асуулга болон ярилцлагын арга ашиглан Хил хамгаалах ерөнхий газар, “Замын үүд” боомт, “Чингис хаан” Олон улсын нисэх буудлаас үйлчилгээ авсан нийт 333 иргэдийг хамруулсан. Судалгаанд оролцогчдыг байршлаар нь ялган авч үзвэл Хил хамгаалах ерөнхий газраас 17, Замын-Үүд боомтоос 133, Чингис хаан ОУНБ-с 180 иргэн, ААНБ-ын төлөөлөл тус тус судалгаанд хамрагдсан байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын байршил

№	Байршил	Иргэд
1.	Хил хамгаалах ерөнхий газар	17
2.	Замын-Үүд боомт	133
3.	Чингис хаан ОУНБ	180
Нийт		330

Судалгаанд оролцогч эмэгтэйчүүдийг хүн ам зүйн шинж, насны байдлаар нь ялган үзвэл 20.9 хувь нь 25-аас доош насныхан, 22.4 хувь нь 25-34 насныхан, 20.3 хувь нь 35-44 насныхан, 24.5 хувь нь 45-54 насныхан, бол 11.8 хувь нь 55-аас дээш насныхан байна.


Судалгаанд оролцогчдын боловсрол эзэмшсэн байдлыг шинжилж үзэхэд оролцогчдын 0.9 хувь нь бага, 22.1 хувь нь дунд, 26.4 хувь нь бүрэн дунд боловсролтой байна. Судалгаанд хамрагдсан 330 хүний ихэнх нь буюу 39.7 хувь нь дээд боловсролтой иргэд байна. Хүснэгт 2-д судалгаанд оролцогчдын хүн ам зүйн шинж байдлыг дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн шинж байдал

Судалгаанд оролцогчид	Тоо (N=330)	Хувь
Нас		
25-аас доош	69	20.9%
25-34	74	22.4%
35-44	67	20.3%
45-54	81	24.5%
55-аас дээш	39	11.8%
Боловсрол		
Бага	3	0.9%
Дунд	73	22.1%
Бүрэн дунд	87	26.4%
Дээд	131	39.7%
Бусад	36	10.9%
Total	330	100%


Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдлаар нь ялган авч үзвэл 0.3 хувь нь ОУБ-д, 7 хувь нь ТББ-д, 10.9 хувь нь тэтгэвэрт, 11.8 хувь нь хувийн байгууллагад ажилладаг бол 19.7 хувь нь ажилгүй, 20.9 хувь нь хувиараа бизнес эрхэлдэг, нийт 29.4 орчим хувь нь төрийн байгууллагад ажилладаг гэж хариулсан байна (Зураг 1).

Зураг 2. Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал /хувиар/




Хил хамгаалах байгууллагаас сүүлийн 1 жилийн дотор хэдэн удаа үйлчилгээ авсан талаар оролцогчдын асуултад хариулсан байдлаас харахад хамгийн олон удаа буюу 4 болон түүнээс дээш удаа гэж 55.8 хувь хариулсан бол 3 удаа гэж 22.1 хувь нь, 2 удаа гэж 13.3 хувь нь, анх удаа гэж 8.8 хувь нь тус тус хариулсан байна.

Зураг 3. Судалгаанд оролцогчдын ХХБ-с үйлчилгээ авсан давтамж /хувиар/



Хил хамгаалах байгууллагаас ямар шаардлагын улмаас үйлчилгээ авч байгааг тодруулсан асуултад нийт оролцогчдын 43 хувь нь хилийн бүсэд нэвтрэх, 42 хувь нь хилийн зурвас нэвтрэх гэж хариулсан бол 15 хувь нь бусад шалтгаанаар гэж хариулжээ.

Зураг 4. Хил хамгаалах байгууллагаас үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлага



5.2 Хил хамгаалах байгууллагын мэдээллийн ил тод байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

“Хил хамгаалах байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний “6.Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, ил тод байдлыг хангах” зорилтын хүрээнд: 6.2-т туссан “Хил хамгаалах байгууллагын алба, үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах” арга хэмжээг хэрэгжүүлж дараах ажлыг хийсэн. Үүнд:

- Хил хамгаалах байгууллын үйл ажиллагаагаа Bro.gov.mn, “Эх орны манаа” сонин, “Хилчин” студи, “Хилчин” сэтгүүл, “Хил хамгаалах байгууллага” цахим хуудсаар олон нийтэд тогтмол сурталчилдаг.
- “Хил хамгаалах байгууллага” цахим хуудсанд хилчдийн ололт амжилтын талаар 213 видео, 357 фото мэдээ, бусад мэдээллийн сайтуудад 37 удаа мэдээ бэлтгэн өгч, олон нийтэд сурталчилсан
- Эх орны манаа сонины 24 дугаарыг эрхлэн гаргаж, хилчдэд хүргэн, өдөр тутмын 2 сонинд 7 нийтлэл, мэдээ нийтлүүлсэн

- Шинжлэх ухаан, онол арга зүй, танин мэдэхүйн “Хилчин” сэтгүүлийн 2 дугаарыг эрхлэн
- гаргасан
- “Сүлдэт баганын дэргэдээс” нэвтрүүлгийн 8 дугаар, ШШГЕГ-тай хамтран “Тангараг нэгт эрчүүд”, ТВ25 телевизтэй “Танайд хоноё”, МҮОНТ-тэй “Амьдралын загвар” нэвтрүүлэг, хилчдийн албаны онцлогийг харуулсан “Аавын хүү” богино хэмжээний уран сайхны кино, хурандаа З.Хийсийн тухай “Баруун хилийн домогт хурандаа” хөрөг нэвтрүүлэг, Халхын голын байлдааны ялалтын 85 жилийн ойн хүрээнд “Зарлаагүй дайны гэрч”, Хилчин генералууд, “Эх оронтойгоо хуваалцсан амьдрал” зэрэг нэвтрүүлэг, Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачлагчаар 2024 оныг Ахлагчийн жил болгон зарласантай холбогдуулан ахлагчийн албыг сурталчилсан 9 контент бэлтгэн харилцан ажиллагаатай телевизүүдээр нэвтрүүлсэн
- “Өглөө” хөтөлбөрт 3 удаа ахлагчийн бүрэлдэхүүнийг оролцуулж, ахлагчийн албыг сурталчилсан
- “Сэтгүүлчид торгон хилд” аяныг ХЦ-ийн 0286-р ангийн хариуцсан хэсэгт зохион байгуулж, 4 нийтлэл, 12 видео болон фото мэдээ, 4 рийл, 1 нэвтрүүлгийг тус тус бэлтгэж, олон нийтэд хүргэсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Цаашлаад 6.3-т туссан “Улсын хилийн музейг шинэчлэн, олон нийтэд үйлчлэх” арга хэмжээг хэрэгжүүлж: ХХЕГ-ын даргын 2023 оны А/269-р тушаалаар томилогдсон ажлын хэсэг Улсын хилийн музейг шинэчлэхээр холбогдох зураг төсөл, тооцоо судалгааг гаргаж, засварын бараа материалыг худалдан авч, тохижилт засварын ажлууд хийгдэж байна. Улсын хилийн түүхийн танхимын ерөнхий засвар хийгдэж дууссан, үзүүлэг, дэглэлтийн ажил хийгдэж байна. Улсын хилийн музейг 2024 онд 2300 хүнд үйлчлэхээр төлөвлөснөөс 2024.11.20-ны байдлаар нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутан, сонсогч, иргэн, нийт 2100 хүнд үзүүлж, Хил хамгаалах байгууллага, хилчдийн алба, үйл ажиллагааг сурталчлаад байна.

Хил хамгаалах ерөнхий газрын мэдээллийн ил тод байдал үнэлгээ нь 2024 оны 2 дугаар улирлын байдлаар /Shilen.gov.mn/-д 100%-ийн үнэлгээгээр дүгнэгдсэн байна. Гэсэн хэдий ч судалгааны багийн гишүүд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-г удирдлага болгон байгууллагын нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах, нийтлэх, шинэчлэх байдлын хэрэгжилтийг судлав.

Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг дараах эрх зүйн актыг үндэслэв. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.8-д заасны дагуу олон нийтэд мэдээлсэн эсэх
- Нээлттэй мэдээллийг хуулийн 8.2-8.6-д заасан зохицуулалтын хүрээнд бүрэн гүйцэд тусгасан эсэх

Хил хамгаалах байгууллагын олон нийттэй харилцах болон мэдээлэл сурталчилгааны ажлын байдлыг нэг талаас олон нийтийн мэдээллийн хэрэгцээ, хайлтаар тодорхойлж болох бол нөгөө талаас Хил хамгаалах ерөнхий байгууллагын ил тод байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийг үйл ажиллагаандаа ашиглаж буй байдлыг харж болно.

Тийм учраас судалгааны дараагийн асуулт Хил хамгаалах байгууллагын мэдээллийн ил тод байдлын талаарх иргэдийн санаа бодлыг тандан мэдэхэд чиглэгдсэн. Эхний асуулт болох та Хил хамгаалах ерөнхий газрын болон хилийн боомтын талаарх мэдээллийг ямар сувгаар голлон хүлээн авдаг вэ гэх асуултад оролцогчдын хариулсан байдлыг нэгтгэн шинжилж үзэхэд дийлэнх буюу 146 оролцогч нийгмийн сүлжээнээс Хил хамгаалах байгууллагын талаарх мэдээллийг авдаг гэж хариулсан бол цахим хуудаснаас гэж 40, хил хамгаалах байгууллагаас гэж 32, найз нөхөд, хамаатан садан 28 зурагт радио 23, төрийн бусад байгууллага 22, сонин сэтгүүл 15, ам дамжсан яриа 11, брошур тараах материал 8 болон бусад гэж 5 оролцогч тус тус хариулсан байна.

Зураг 5. Хил хамгаалах байгууллагын талаарх мэдээлэл хүлээн авдаг суваг /тоогоор/




Зураг 4-өөс харахад Иргэдийн ихэвчлэн мэдээлэл хүлээн авдаг эх сурвалжаар нийгмийн сүлжээ, байгууллага, интернет, зурагт гэсэн мэдээллийн сурвалжууд нэрлэгдэж байна.

Цаашлаад Хил хамгаалах ерөнхий газрын вэб сайт дахь мэдээллийн ил тод байдалд иргэдийн өгсөн үнэлгээ нэгтгэн үзэв. Судалгаанд хамрагдсан 330 оролцогчдын 161 нь Хил хамгаалах ерөнхий газрын мэдээллийн нээлттэй байдлыг маш сайн, 135 сайн, 28 дунд гэж хариулсан бол тааруу гэж 6 оролцогч санал өгсөн, харин маш муу гэж үнэлсэн

Зураг 6. Хил хамгаалах байгууллагын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээ /тоогоор/


оролцогч байхгүй байна. Эндээс дүгнэхэд Хил хамгаалах ерөнхий газрын мэдээллийн нээлттэй байдал хангалттай түвшинд байгааг илтгэж байна (Зураг 5).

ХХЕГ ба хилийн боомтын бодлого хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй



ил тод байдалд өгсөн иргэдийн үнэлгээг Зураг 6-д харуулав. Зургаас харахад ХХЕГ ба хилийн боомтын бодлого хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй ил тод байдалд “тийм” гэж 139 оролцогч “үгүй” гэж 104 оролцогч, “мэдэхгүй” гэж 87 оролцогч тус тус хариулсан байна.


Зураг 7. ХХЕГ ба хилийн боомтын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нээлттэй ил тод байдалд өгсөн иргэдийн үнэлгээ



ХХЕГ ба хилийн боомтын бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны нээлттэй ил тод байдалд өгсөн иргэдийн үнэлгээнээс дүгнэж үзэхэд судалгаанд оролцсон иргэдийн 42 хувь нь нээлттэй ил тод байж чаддаг гэсэн бол дийлэнх буюу 31 хувь нь үгүй, 26 орчим хувь нь мэдэхгүй гэж хариулснаас харахад цаашид мэдээллийг ил тод, нээлттэй болгоход анхаарч ажиллах шаардлагатай байгааг судалгааны дүн харуулж байна.


Судалгааны дараагийн асуулт Та ХХЕГ-ын цахим хуудаст зочилж байсан уу? Хэрэв “Тийм” бол хэрэгтэй мэдээлэл авч чадсан уу гэсэн асуултыг судалгаанд оролцогчдоос асуусан.

Зураг 8. ХХЕГ-ын цахим хуудсанд зочилсон байдал



Судалгаанд оролцогчдын 87 буюу 26.4 хувь нь мэдэхгүй, 129 буюу 39.1 хувь нь үгүй, 114 буюу 34.5 хувь нь тийм гэж хариулсан байна. Тэгвэл хэрэв цахим хуудсанд зочилсон бол хэрэгтэй мэдээллээ олж авч чадсан эсэх талаар асуусан асуултад оролцогчдын 15 тийм, 13 үгүй, 14 мэдэхгүй гэж хариулсан байна.

Зураг 9. ХХБ-ын цахим хуудснаас хэрэгтэй мэдээллээ олж авсан байдал



Зургаас харахад цахим хуудсанд зочилсон бол хэрэгтэй мэдээллээ олж авч чадсан эсэх талаар асуусан асуултад нийт 42 оролцогч хариулсан бол бусад буюу 288 оролцогч энэ асуултад ямар нэг байдлаар хариулаагүй байна. Эндээс дүгнэж үзэхэд ХХЕГ-ын цахим хуудсыг сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Та ХХЕГ-тай утсаар холбогдож байсан уу Хэрэв Тийм бол хэрэгтэй мэдээлэл авч чадсан уу? гэсэн асуултад оролцогчид хэрхэн хариулсан байдлыг зураг 9-д харуулав.

Зураг 10. ХХБ-ын лавлах утсанд холбогдсон байдал



Зургаас харахад ХХЕГ-тай утсаар холбогдож байсан гэж 41, үгүй 177, мэдэхгүй 28 хүн хариулсан бол хэрэв тийм бол хэрэгтэй мэдээлэл авч чадсан уу? гэсэн асуултад тийм гэж 39 хүн хариулсан бол мэдэхгүй гэж 26 хүн байна. Үгүй гэж хариулсан оролцогч байхгүй бол бусад оролцогчид энэ асуултад хариулаагүй байна. Эндээс дүгнэж үзэхэд иргэд ХХЕГ-тай холбоотой мэдээллийг авахдаа утас ашиглаж авах байдал хангалтгүй байна. Магадгүй утсаар мэдээлэл авахад төвөгтэй эсвэл залгасан иргэдэд мэдээлэл өгдөг

утас завгүй байдаг. Эсхүл өөр сувгаар (олон нийтийн цахим сүлжээ, ХХЕГ-ын пэйж хуудас) мэдээлэл хүлээн авахыг илүүд үздэг байх талтай.

Хүснэгт 3. ХХБ-ын мэдээллийн ил тод нээлтэй байдалд өгсөн иргэдийн үнэлгээ

№	Асуулт	Дундаж үнэлгээ
1.	- Хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;	4.8
2.	- Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлтэй байх;	4.9
3.	- Мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шуурхай, хялбар байх;	4.8
4.	- Мэдээлэл, үйлчилгээ нь ойлгомжтой, үнэн зөв, бүрэн байх;	4.9
5.	- Нийтийн мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд эрх тэгш байх;	4.95
6.	- Нийтийн мэдээллийн дэд бүтэц нь харилцан уялдаатай, нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байх;	4.9
Дундаж үнэлгээ		4.87

5.3 Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний шуурхай байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

Байгууллагын 2024 оны 1-р дүгээр сарын 1-нээс 11 дүгээр сарын 28-ийг хүртэлх хугацаанд үндсэн чиг үүргийн статистик мэдээ, инфографик мэдээ, үйл ажиллагааны тайлан мэдээ, төлөвлөгөө болон бусад төлөвлөгөөний биелэлт нь байгууллагын нууцад хамаарах ажил үйлчилгээнээс шалтгаалан мэдээллийн хүрээнд чиг үүргийн хэрэгжүүлсэн ажилд үнэлгээ хийсэн.

Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний шуурхай байдлын талаар хэрэглэгчдээс асуулга авахдаа Ликертийн 5 шкалын хэмжээсийг ашиглан мэдээллийг цуглуулсан. Өөрөөр хэлбэл асуулгын асуулт бүрийг 1-5 хүртэлх оноогоор дүгнэсэн. Жишээ нь: 1-маш муу, 2-муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн гэсэн сонголтууд бүхий 5 хүртэл оноогоор дүгнэж оролцогчдын хариултад боловсруулалт хийх дундаж үнэлгээг гаргав (Хүснэгт 2).


Хүснэгт 4. ХХБ-ын үйлчилгээний шат дамжлага, шуурхай байдалд өгсөн иргэдийн үнэлгээ

№	Асуулт	Дундаж үнэлгээ
1.	Хүссэн үйлчилгээг авах шат дамжлага хялбар	4.94
2.	Үйлчилгээг тогтсон хугацаанд үзүүлэх байдал	4.81
3.	Үйлчилгээний цаг хугацаа алдахгүй шуурхай байдал	4.52
4.	Үйлчилгээ авах дараалал, чирэгдэлгүй байдал	4.74
5.	Иргэдийн бүрдүүлэх материалын уялдаа холбоо	4.66
6.	Нэг хүн дээр дахин дахин очиж чирэгдэл үүсгэхгүй байдал	4.88
Дундаж үнэлгээ		4.75

Судалгаанд оролцсон иргэд хүссэн үйлчилгээг авах шат дамжлага хялбар байдалд 4.94, үйлчилгээг тогтсон хугацаанд үзүүлэх байдалд 4.81, үйлчилгээний цаг хугацаа алдахгүй шуурхай байдалд 4.52, үйлчилгээ авах дараалал, чирэгдэлгүй байдалд 4.74, иргэдийн бүрдүүлэх материалын уялдаа холбоотой байдалд 4.66, нэг хүн дээр дахин дахин очиж чирэгдэл үүсгэхгүй байдалд 4.88 оноотой үнэлгээг тус тус өгсөн байна. иргэд хүссэн үйлчилгээг авах шат дамжлага хялбар байдалд иргэд хамгийн өндөр үнэлгээ өгсөн бол иргэдийн бүрдүүлэх материалын уялдаа холбоотой байдалд хамгийн бага үнэлгээ өгсөн нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Үүний дараагаар хэрэглэгчдээс Хил хамгаалах байгууллагаас үйлчилгээ авахад хир хугацаа зарцуулдаг вэ гэсэн асуултыг асуусан. Хэрэглэгчдийн хариултыг зураг 9-д дэлгэрэнгүй харуулав.


Зураг 11. ХХБ-с үйлчилгээ авахад хэрэглэгчийн зарцуулдаг хугацаа /тоогоор/



Зургаас харахад нийт судалгаанд оролцогчдын 135 буюу 41.3 хувь нь 1-ээс бага буюу нээх хугацаа ороогүй, 65 буюу 19.9 хувь нь 1-2 өдөр, 54 буюу 16.5 хувь нь 3-7 өдөр, 51 буюу 15.6 хувь нь 7-14 өдөр гэж хариулсан бол 22 буюу 6.7 хувь нь 14 дээш буюу ойролцоогоор 2 долоо хоногийг хугацааг зарцуулдаг нь судалгаанд оролцсон иргэдийн хариултаас харагдаж байна. Эндээс дүгнэж үзэхэд Хил хамгаалах байгууллагын иргэд үйлчилгээ үзүүлдэг хугацаа бага үйлчилгээний түргэн шуурхай байдал сайн түвшинд байна гэж судлаачид дүгнэж байна.

Хил хамгаалах байгууллага болон ХХЕГ үйлчилгээний хүнд сурталгүй байдалд иргэдийн өгсөн үнэлгээг нэгтгэн дүгнэж үзэхэд хийт санал өгсөн иргэдийн дийлэнх олонх буюу 166 хүн маш сайн гэсэн үнэлгээг өгсөн байна.

Зураг 12. Үйлчилгээний хүнд сурталгүй, шуурхай байдал иргэдийн өгсөн үнэлгээ



5.4 Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний хүртээмжтэй, ойлгомжтой байдалд иргэдийн өгсөн үнэлгээг хүснэгт-3 харуулав. байгууллагын хаягжилт 4.91, үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарь 4.90, доторх зохион байгуулалт 4.92, дотоод хаягжилт, мэдээллийн самбар 4.91, үйлчилгээ авах дараалал 4.87, бүрдүүлэх материалын жагсаалт 4.93, үнэ тариф 4.71, албан хаагчийн нэр 4.95, албан тушаал, ажилтнуудын тоо, хүрэлцээ 4.96, веб сайт дээрх мэдээлэл 4.24, онлайнаар мэдээлэл авах 4.14, утсаар мэдээлэл авах 4.92 гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна.

Хүснэгт 5. ХХБ-ын үйлчилгээний хүртээмжтэй байдалд өгсөн иргэдийн үнэлгээ

№	Асуулт	Дундаж үнэлгээ
1.	Байгууллагын хаягжилт	4.91
2.	Үйлчилгээ үзүүлэх цагийн хуваарь	4.90
3.	Доторх зохион байгуулалт, дотоод хаягжилт	4.92
4.	Мэдээллийн самбар	4.91
5.	Үйлчилгээ авах дараалал	4.87
6.	Бүрдүүлэх материалын жагсаалт	4.93
7.	Үнэ тариф	4.71
8.	Албан хаагчийн нэр, албан тушаал	4.95
9.	Ажилтнуудын тоо, хүрэлцээ	4.96
10.	Веб сайт дээрх мэдээлэл	4.24
11.	Онлайнаар мэдээлэл авах	4.14
12.	Утсаар мэдээлэл авах	4.92
Дундаж үнэлгээ		4.78

Хамгийн өндөр үнэлгээг албан хаагчийн нэр, албан тушаал, тоо хүрэлцээ зэрэгт өгсөн бол тааруу үнэлгээг онлайнаар мэдээлэл авах гэж хариулсан нь цаашид ХХЕГ иргэдэд мэдээлэл өгдөг онлайн сувгийн үйлчилгээ, шуурхай байдалд анхаарах шаардлагатайг харуулж байна.

5.5 Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний чанарт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

Үйлчилгээний чанартай байдлыг Хил хамгаалах байгууллагаас үйлчилгээ үзүүлсэн Чингис хаан Олон Улсын нисэх буудал, Замын-Үүдийн хилийн боомтоор үйлчлүүлсэн иргэдээс авсан асуумжийн судалгааны үр дүнд тулгуурлан шинжилгээ хийсэн. Үйлчилгээний чанартай байдлыг мэдээллийн хангалттай байдал, ажилтнуудын тооны хүрэлцээтэй байдал, мэргэжлийн ур чадварын хангалттай байдал, ажлын туршлага зэргийг харгалзан үнэлсэн. Үйлчилгээ авсан иргэдийн шаардлагатай үйлчилгээгээ авч чадсан эсэхийг нийт судалгаанд хамрагдагчийн хувьд болон үйлчилгээ тус бүрийг харууллаа.

Хүснэгт 6. Хил хамгаалан байгууллагын үйлчилгээний чанарт өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

№	Асуулт	Дундаж үнэлгээ
1.	Ажилтнуудын мэргэшсэн байдал	4.9
2.	Ажилтнуудын үйлчилгээний соёл	4.8
3.	Үйлчилгээний түргэн шуурхай байдал	4.9
4.	Үнэ тариф	4.9
5.	Үйлчилгээ үзүүлж байгаа орчин нөхцөл	4.9
6.	Үйлчилгээ үзүүлэх шат дамжлага	4.7
7.	Онлайн болон утсаар мэдээлэл өгөх, үйлчилгээ үзүүлэх байдал	4.9
8.	Үйлчилгээ үзүүлж буй орчин нөхцөл	4.8
9.	Үйлчилгээ үзүүлж буй тоног төхөөрөмж	4.5
Дундаж үнэлгээ		4.81

Энэхүү үр дүн нь Монгол Улсын ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн О5 дугаар тогтоол, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.6.7 дахь заалт, Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны 2023 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Ёс зүйн хорооны үйл ажиллагааны дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт, 4.8, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн ХХЕГ-ын даргын 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/120 дугаар тушаалаар батлагдсан “Хилийн ангиудад ёс зүйн дэд хороо байгуулах тухай”, хавсралтаар баталсан Хил хамгаалах байгууллагын “Ёс зүйн дүрэм²”-ийг чанд хэрэгжүүлэх, ёс зүйн элдэв зөрчил гаргахгүй байхад чиглэгдсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг олон хэлбэрээр зохион байгуулж, “Ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг алба хаагчдын сарын ажлыг дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болгон, дүгнэж хэвшсэнтэй холбоотой гэж харагдаж байгаа юм.

5.6 Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ёс зүй, мэдлэг ур чадварт өгсөн иргэдийн үнэлгээ

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ёс зүйг иргэдээр үнэлүүлэхдээ хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ёс зүйн дүрмийг мөрдлөгө болгосон. Энэхүү дүрмээр хил хамгаалах байгууллагын бүрэлдэхүүний үүргээ гүйцэтгэх явцад дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, түүнтэй холбогдсон үйл ажиллагааг зохицуулдаг. Мөн Хил

² www.bro.gov.mn Хил хамгаалах ерөнхий газрын албан ёсны вэб сайт. Бодлого эрх зүй, холбогдох журам заавар.

хамгаалах байгууллагын өмнө тавигдсан зорилтыг амжилттай хэрэгжүүлэх, албан хаагчдаас хуульд заасан эрх, үүргээ биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү дүрмийн зорилго оршдог. Өргөсөн тангарагтаа үнэнч байж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаандаа эрхэмлэвэл зохих зан үйлийн нийлбэр цогцыг Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ гэж дүрэмд заасан байдаг. Хил хамгаалах байгууллагын албан хаагчийн ёс зүй нь албан үүргээ амжилттай гүйцэтгэх үндсэн нөхцөлийн нэг бөгөөд бүрэлдэхүүнээс энэхүү хэм хэмжээг сахин биелүүлэхийг шаардаж байдаг.


Мөн хил хамгаалах байгууллагын алба хаагчдын мэргэжил ур чадвар, ёс зүйг үнэлэх нь тухайн байгууллагын үйл ажиллагааг үнэлэхд чухам хүчин зүйл болно гэж судлаачид үзэж байна.

Хүснэгт 7 Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын ёс зүйн байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

№	Асуулт	Дундаж үнэлгээ
1.	Биеэ авч яваа байдал	4.9
2.	Боловсрол мэдлэг	4.8
3.	Мэргэжлийн ур чадвар	4.95
4.	Шударга байдал	4.7
5.	Тэгш хандаж үйлчлэх байдал	4.9
6.	Хариуцлагатай байдал	4.8
Дундаж үнэлгээ		4.84

Биеэ авч яваа байдал 4.9, Боловсрол мэдлэг 4.8, Мэргэжлийн ур чадвар 4.95, Шударга байдал 4.7, Тэгш хандаж үйлчлэх байдал 4.9, Хариуцлагатай байдал 4.8 оноог тус тус өгсөн байна. Эндээс дүгнэж үзэхэд хил хамгаалах байгууллагын алба хаагчид хууль, дүрэм, журамд заасан ёс зүйн байдлын мөрдөж ажилладаг нь харагдаж байна. Энэ шинжилгээний үр дүнг нарийвчилж харвал дараах байдалтай байна.

Зураг 13. Хил хамгаалах байгууллагын албан хаагчдын ёс зүйд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ




Судалгаанд оролцсон иргэдийн үнэлгээнээс харахад судлаачдийн асуусан асуултад иргэд сайн, маш сайн гэж хариулсан хариулт жин дарж байна. Жишээ нь биеэ авч яваа байдал 76 хувь, боловсрол мэдлэг мэргэжлийн ур чадвар 72 хувь, шударга байдал 61,7 хувь, тэгш хандаж үйлчлэх байдал 68 хувь, хариуцлагатай байдал 76 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

5.7 Үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдалд хэрэглэгчийн үнэлгээ

Энэ бүлэгт Хил хамгаалах байгууллагатай холбоотой үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдал, алба хаагчдын харилцаа, санал, гомдол хүлээж авах боломжит байдал зэрэгт шинжилгээ хийсэн. Монгол Улсын Үндсэн хуульд 17 зүйлийн 18-д Монгол Улсын иргэн улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно гэж заасан байдаг. Иргэд гадаадад явах, эх орондоо буцаж ирэх энэхүү үйл явцад Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа хэрхэн уялдаж байгааг нягтлах, тодруулах нь энэ судалгааны бас нэг зорилго байсан.

Зураг 14. Хил хамгаалан байгууллагын үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ /дэлгэрэнгүй/



Хил хамгаалах байгууллагатай холбоотой үйлчилгээний хүний эрхийг хүндэтгэсэн байдал, алба хаагчдын харилцаа, санал, гомдол хүлээж авах боломжит байдал зэрэгт шинжилгээний үр дүнгээс харахад нийт оролцогчдын 95 гаруй хувь нь маш сайн, сайн гэж хариулсан байна.

Хүснэгт 8. Хил хамгаалах байгууллага үйлчилгээндээ хүний эрхийг хүндэтгэсэн байдалд өгсөн хэрэглэгчийн үнэлгээ

№	Асуулт	Дундаж үнэлгээ
1.	Хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж буй байдал	4.9
2.	Үйлчилгээг эрх тэгш хүргэх байдал	4.8
3.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авахад тохиромжтой байдал	4.95
4.	Санал, гомдол илэрхийлэх боломжтой байдал	4.7
Дундаж үнэлгээ		4.87

Цаашлаад иргэд Хил хамгаалах байгууллын үйлчилгээнд хүний эрхийг хүндэтгэсэн байдлыг дундаж үнэлгээг хувилж үзэхэд дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд: хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлж буй байдалд 4.9, үйлчилгээг эрх тэгш хүргэх байдалд 4.8, хөгжлийн бэрхшээлтэй иргэн үйлчилгээ авахад тохиромжтой байдалд 4.95, санал, гомдол илэрхийлэх боломжтой байдалд 4.7 гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна. Дүгнэж үзэхэд Хил хамгаалах байгууллын үйлчилгээнд хүний эрхийг хүндэтгэсэн байдал боломжийн түвшинд байна гэж судлаачид үзэж байна.

5.7 Ярилцлагын судалгааны үр дүн

Хил хамгаалах байгууллагын төрийн үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэд, аж ахуйн нэгжийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход хэрэглэгчийн үнэлгээний судалгаанд асуулгын судалгаагаар илрээгүй болон тодруулах шаардлагатай зарим үр дүнг бататгах үүднээс Хил хамгаалах ерөнхий газар, Чингис хаан ОУНБ, болон Замын-Үүд боомтоор үйлчлүүлэгч иргэдээс 18 хүнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч ярилцлага хийн Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний талаар санаа бодлыг тандан ярилцав.

Ярилцлага хийсэн алба хаагч, иргэдээс гарсан саналыг нэгтгэн үзвэл хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

- Хил хамгаалах ерөнхий газрын “Нэг цэгийн үйлчилгээ”-г зөвхөн цэрэг татлагатай холбоотойгоор ажиллуулахаас гадна иргэдэд байнгын нэг цэгийг үйлчилгээг үзүүлдэг байх
- Чуулгын алба хаагчдын бэлтгэл хийдэг өрөөний хүрэлцээ муутай, агааржуулалт байхгүй стандартад нийцэхгүй нөхцөлд бүжигчид, дуучид бэлтгэл хийгдэж байна. Иймд нөхцөл байдалд тохируулан агаар цэвэршүүлэх, агаар сэлгэх зэрэг арга хэмжээг авч ажиллах.

“Замын-Үүд” боомтын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар иргэдтэй хийсэн ярилцлагыг нэгтгэн дүгнэж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Дэд бүтцийг шинэчлэл: Хилийн зурвас дэд бүтцийг сайжруулах, зам, шалган нэвтрүүлэх цэгүүдийг засварлах, тоног төхөөрөмжийг шинэчлэх. (Тухайлбал: Хилийн бүсэд ариун цэврийн байгууламж байгуулах)
- Хэрэглэгчийн үйлчилгээ: Үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд алба хаагчдад сургалт явуулах, хэрэглэгчдийн санал хүсэлтийг анхаарч үзэх. (Тухайлбал: Замын-Үүдийн хилийн боомтод нотариат ажиллуулах)
- Хяналт, мониторинг: Үйлчилгээний чанарыг тасралтгүй хянах, задлан шинжлэх систем бий болгох.

Эдгээр алхмуудыг хэрэгжүүлснээр Замын-Үүд боомтын үйлчилгээний чанарыг сайжруулах боломжтой.

“Чингис хаан” ОУНБ-ын үйл ажиллагааг сайжруулахад хэрэглэгчид дараах алхмыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн үзэж байна. Үүнд:

- Аюулгүй байдлын сайжруулалт: Шалгагч алба хаагчдын эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах систем суурилуулсан боловч ажлын цагаар өөрсдөө тохиргоо хийх нөхцөл бүрдүүлэх,
- Иргэдийн оролцоо: Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэдийн санал, хүсэлтийг сонсох, үүнд тулгуурлан сайжруулалт хийх.

Эдгээр зөвлөмжүүд нь Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, тав тухыг дээшлүүлэх боломжтой гэж ярилцлагад оролцсон иргэд үзэж байна.

ЗУРГАА. ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

6.1. Судалгааны дүгнэлт

Судалгааны баг Хил хамгаалах байгууллагын үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэд, аж ахуйн нэгжийн хандлагыг тандан судаллаа. Багийн гишүүд хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ дараах зорилтыг дэвшүүлж ажилласан. Үүнд: хил хамгаалах байгууллагын иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдал, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх, хил хамгаалах байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах, иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн үзүүлэх үйлчилгээг сайжруулах, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, мөн хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд цаашид анхаарах асуудал, сайжруулах арга замыг тодорхойлсон дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэг болно.

Судалгааны зорилтот бүлэгт Хил хамгаалах байгууллагаар үйлчлүүлж буй иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамруулан судалгааны өгөгдлийг цуглуулсан. Судалгаанд Хил хамгаалах Ерөнхий газар, Чингис хаан” ОУ-ын нисэх буудал, “Замын -Үүд” авто болон төмөр замын боомт зэрэг газруудыг хамруулсан. Хэрэглэгчээр байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлын ач холбогдол нь Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, цаашид анхаарах асуудал, үйлчилгээг сайжруулах арга замыг тодорхойлон дүгнэлт, зөвлөмж боловсруулах зэрэгт оршиж байна.

Судалгааны баг Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийхдээ 1) мэдээллийн ил тод, нээлттэй байдал, 2) үйлчилгээний шуурхай байдал, 3) үйлчилгээний хүрээтжтэй байдал, 4) үйлчилгээний чанар, 5) хүний эрх хүндэтгэсэн байдал, 6) албан хаагчдын ёс зүй, ажлын ур чадвар гэсэн үндсэн 6 үзүүлэлтийг гол чиглэл болгон үнэлүүлэхээр асуулга боловсруулж ажиллаа. Үнэлгээг хийхдээ чиглэл бүрт байх асуудлыг 1-5 (1-маш муу, 2- муу, 3-дунд, 4-сайн, 5-маш сайн) оноогоор үнэлж дундыг гаргасан.

Ингээд судалгаанд оролцсон 330 иргэний Хил хамгаалах байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлт бүрээр өгсөн үнэлгээг нэгтгэн дүгнэж үзвэл нийт үнэлгээ

4.82 буюу **98%** оноотой дүгнэгдлээ. Нийт үнэлгээг шалгуур үзүүлэлт бүрээр нарийвчлан хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Хил хамгаалах байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд өгсөн хэрэглэгчийн үнэлгээний нэгдсэн дүн

№	Чиглэл	Үнэлгээ
1.	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	4.87
2.	Үйлчилгээний шуурхай байдал	4.75
3.	Үйлчилгээний хүрээмжтэй байдал	4.78
4.	Үйлчилгээний чанар	4.81
5.	Хүний эрх хүндэтгэсэн байдал	4.87
6.	Албан хаагчдын ёс зүй, ажлын ур чадвар	4.84
Нийт үнэлгээ		4.82 (98%)

Хүснэгтээс харахад иргэд мэдээллийн ил тод, нээлттэй байдалд 4.87, үйлчилгээний шуурхай байдалд 4.75, үйлчилгээний хүрээмжтэй байдалд 4.78, үйлчилгээний чанарт 4.81, хүний эрх хүндэтгэсэн байдалд 4.87, албан хаагчдын ёс зүй, ажлын ур чадварт 4.84 үнэлгээг тус тус авсан байна. Цаашилбал иргэд мэдээллийн ил тод, нээлттэй байдалд 4.87 буюу хамгийн өндрөөр үнэдсэн бол Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний шуурхай байдалд хамгийн бага буюу 4.75 оноо өгсөн байна. Гэхдээ энэ үнэлгээ (4.75) судалгааны шалгуур үзүүлэлт бүрийн дундажтай харьцуулахад өндөр үнэлгээ гэж дүгнэж байна.

Цаашилбал судалгаанд хамрагдсан иргэд, ААНБ-ын төлөөлөл нь их ачааллын улиралд хилийн шалгагч нарын орон тоог нэмэх, үйлчилгээний заал, танхимын хүрэлцээ багтаамж, тохь тухын байдал эрс сайжирсан гэж үзэж байна. Хилийн шалган нэвтрүүлэх боомтод иргэдтэй хамгийн их нүүр тулж ажилладаг хилийн шалгагч нарын хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээ, бичиг баримт шалгуулах \штамп дарах\, хилийн боомтоор үйлчлүүлэхэд ХХБ-ын үзүүлж буй үйлчилгээнээс шалтгаалсан чирэгдэл гардаггүй, түргэн шуурхай үйлчлүүлдэг гэж нийт судалгаанд оролцогчдын 98 хувь нь хариулснаас үзвэл иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж байна гэж дүгнэх үндэстэй.

Байгууллагатай холбоотой мэдээллийг иргэд ихэвчлэн нийгмийн цахим сүлжээ, зурагт гэсэн эх сурвалжаас авч байна. Цаашид эдгээр мэдээллийн эх сурвалжаас мэдээ, мэдээлэл авахаас гадна лавлах утас, утасны мессеж гэсэн эх сурвалжаас мэдээллийг түлхүү авах сонирхолтой байна.

Мөн иргэд гол төлөв Хил хамгаалах байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны талаарх мэдээллийг голчлон сонирхож мэдээлэл авч байна. Харин гаалийн үйлчилгээг ялгаж ойлгохгүй Хил хамгаалах байгууллагын үйлчилгээ мэтээр хүлээн авч байгаа нь иргэд өөрсдийн хайхрамжгүй байдлаас шалтгаалан хил хамгаалах байгууллагаас явуулж байгаа мэдээлэлд төдийлөн ач холбогдол өгөхгүй мэдэхгүй байгаа нь харагдаж байна.

Иргэд Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цахим эх сурвалжаас эрэлхийлэхдээ цахим хуудснаас гадна албан ёсны Фейсбүүк хуудсыг ашиглах байдал ихэссэн байна. Энэ нь иргэдийн Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдад илтгэх итгэл, хандлага өндөр харагдаж байна.

Хил хамгаалах байгууллагын үйлчилгээний чанарын талаас илүү хувь нь хангалттай сайн гэж үнэлжээ. Үйлчилгээний шуурхай байдал лавлагаа, мэдээлэл олгох зэрэг нь бусад үйлчилгээтэй харьцуулахад түргэн шуурхай байна. Хил хамгаалах ерөнхий газар, Хилийн боомтод хийсэн судалгаагаар, ХХБ-ын алба хаагчид нь хилийн боомтын аюулгүй байдал, боомтод мөрдөх журмыг хангалттай түвшинд хэрэгжүүлж байна гэж үзлээ.

ХХЕГ-ын даргын 2024 оны “Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийг хэрэгжүүлж, алба хаагчдыг албаны байраар хангах, өөрийн орон сууцтай болоход дэмжлэг үзүүлэх, ажлын байрны эрүүл аюулгүй орчныг бий болгох, ажилтнуудын ажлын ачааллыг стандартын түвшинд ойртуулах талаар төрөл бүрийн арга хэмжээ авч байгаа ч тулгамдсан асуудал хэвээр байгааг алба хаагчдын дунд явуулсан санал асуулгын судалгаагаар орон сууцны хангамж хүрэлцээний байдлыг 30 хувь нь “хангалтгүй”, 38 хувь нь “дунд зэрэг”, 30 хувь нь “хангалттай”, 2 хувь нь “мэдэхгүй”, гэж үзсэн алба хаагчдын албаны амьдрах орон сууцны хангамж хүрэлцээ муутай байгааг үнэлгээний үр дүн харуулж байна. Түүнчлэн судалгааны нээлттэй асуулгын дүнгээс харахад, орон сууцны асуудлыг шийдвэрлэх, алба хаагчдын ажил амралтыг зохицуулах, орон тоог нэмж, ачааллыг бууруулах, эмэгтэй алба хаагчдыг ар гэр, үр хүүхдүүддээ цаг гаргах боломжийг бүрдүүлэх гэсэн саналыг нэлээд гаргаж тавьсан байсан нь дээрх санал бодлыг баталж байна гэж үзлээ. Иймд, алба хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулах асуудлыг хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө оруулалт, төсөв хөрөнгийн асуудлыг хамтад нь менежмент хийх шаардлагатай гэж үзлээ.

6.2 Зөвлөмж

Хил хамгаалах байгууллага нь мэдээ мэдээллийг түгээхдээ зураг, нийгмийн цахим сүлжээ гэсэн түгээмэл мэдээлэл, лавлах утсыг тогтмол байнгын ажиллуулж байгаа боловч гар утасны мессежийн үйлчилгээ ашиглан мэдээлэл өгөх нь иргэд, олон нийтийн хүлээлтийг хангахаар байна.

Мөн интернэтийн эх сурвалж ашиглахдаа зөвхөн вэбсайт, фейсбүүк хуудас гэлтгүй гар утасны аппликейшн ашиглах нь иргэдийн хэрэгцээ, сонирхлыг татах үр дүнтэй арга болж болох юм.

Цаашилбал үзүүлж буй үйлчилгээтэй холбоотой шинэ дүрэм, журам тогтоол шийдвэрүүдийг тухай бүрд нь нийтэд мэдээлэх, үйлчилгээ авахад шаардагдах баримт бичгүүдийг ил тод болгох хэрэгцээтэй байна.

Зарим төрлийн үйлчилгээг ТҮЦ машин, Е Монголиа-аар өгч байгаад үйлчлүүлэгчид сайшаалтай хандаж байгаа бөгөөд олон нийтэд мэдээллийг өргөн хүрээтэй өгөх үйлчилгээний хүрээг өргөсгөх шаардлагатай.

ХХЕГ-ын чиг үүрэг, түүх, хилийн боомтын бодлого, хил нэвтрэх тухай заавар зэрэг мэдээллийг нийгмийн сүлжээ, телевизийн сувгаар голчлон дамжуулах бөгөөд тодорхой боомтоос хамаарч үйлчлүүлж буй иргэд, байгууллагууд ялгаатай ойлголт мэдлэгтэй байгааг анхаарч мэдээллийн хүртээмжийг жигд сайжруулах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Хилийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу ХХБ нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай соёл урлагийн нэгжтэй бөгөөд хилчид болон хил орчмын нутаг дэвсгэрийн ард иргэдэд урлаг соёлын үйлчилгээг хүргэж, ХХБ-ыг сурталчилж, хамтын ажиллагааг бэхжүүлэх үүргийг Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга гүйцэтгэдэг байна.

Нэмж дурдахад ХХЕГ-ын харьяа ХЦДБЧ нь МУ-ын Засгийн газрын болон холбогдох дээд байгууллагын шийдвэрээр 2001 онд дахин байгуулагдсан ба 2024 онд шинээр 305 удаагийн тоглолт зохион байгуулж 35200 гаруй хүнд урлаг соёлоор иргэдэд үйлчилжээ. Тус онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал бүртгэгдээгүй байна. Харин алба хаагчдын бэлтгэлийн өрөөний хүрэлцээ муутай, агааржуулалт байхгүй стандартад нийцэхгүй нөхцөлд бүжигчид, дуучид бэлтгэл хийгдэж байгаа нь цаашид анхаарах асуудал гэж багийн гишүүд дүгнэж байна.

----oOo----